



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС 2020-2023 ОНД
ЗАРЛАСАН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААН
ДАХЬ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА

Улаанбаатар хот

2024 он

Судалгааны мэдээллийг ашиглахтай холбоотой бүх эрхийг “Авлигатай тэмцэх газар” эзэмшинэ.

Тайланд дурдагдаж буй үр дүнг хараат бус байдлаар судлан тодорхойлсон бөгөөд цаашид судалгааны сэдвийн хүрээнд үйл ажиллагааны сайжруулалт хийхэд ашиглагдах мэдээллийн эх сурвалж болгон бэлтгэлээ.

Судалгааны үр дүн нь тодорхой эх үүсвэрүүдээс авсан, үнэн зөв, бодит статистик тоон мэдээлэлд үндэслэгдсэн болно.

АГУУЛГА

НЭГ. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО	4
1.1 Судалгааны ажлын үндэслэл	4
1.2 Судалгааны ажлын зорилго	4
ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	5
2.1 Судалгааны хамрах хүрээ	5
2.2 Судалгааны арга зүй	5
2.3 Судалгааг хийхэд баримталсан зарчим	5
ГУРАВ. ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	6
3.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн талаар	7
3.2. Төрийн худалдан авах ажиллагаан дахь авлигын талаар	7
3.3. Монгол Улсын төрийн худалдан авах ажиллагааны зардлын талаар	8
3.4 Төрийн худалдан авах ажиллагааг авлигаас ангид явуулах нь	10
ДӨРӨВ. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАРТ 2020–2023 ОНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН СУДАЛГАА	12
4.1. Өргөдөл, гомдол, мэдээллийн тоо, хүлээн авсан хэлбэр	12
4.2. Өргөдөл, гомдол, мэдээллийн төрөл	17
4.3. Өргөдөл, гомдол, мэдээллийн хуваарилалт хэлтэс, албаар	21
4.4. Өргөдөл, гомдол, мэдээлэл орон нутгийн харьяаллаар	25
4.5. Өргөдөл, гомдол, мэдээлэл салбараар	26
4.6. Өргөдөл, гомдол, мэдээлэл төрийн албаны ангиллаар	28
4.7 Өргөдөл, гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал	30
ТАВ САНГИЙН ЯАМАНД 2020–2023 ОНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА	45
5.1 Сангийн яаманд ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал	45
ЗУРГАА. МОНОПОЛЫН ЭСРЭГ ГАЗАРТ 2022–2023 ОНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА	51
6.1. Монополын эсрэг газарт ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, салбараар	51
6.2. Монополын эсрэг газарт ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал	52
ДҮГНЭЛТ	54
САНАЛ	59
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	61
Хавсралт №1. Дэлхийн улс орнуудын төрийн худалдан авалтын ДНБ-д эзлэх хувь	63
Хавсралт №2. Өргөдөл, гомдол, мэдээллийн төрөл (2020-2023 он) дэлгэрэнгүй	65
Хавсралт №3. Өргөдөл, гомдол, мэдээллийн хуваарилалт хэлтэс, албаар (2020-2023) дэлгэрэнгүй	67

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АТГ – Авлигатай тэмцэх газар

АБХШНА – Авлигатай тэмцэх газрын Аюулгүй байдал, хяналт шалгалт, нууцын алба

ГАХ – Авлигатай тэмцэх газрын Гүйцэтгэх ажлын хэлтэс

ДНБ (GDP) – Дотоодын нийт бүтээгдэхүүн (Gross domestic product)

ДБ – Дэлхийн банк

ДХБ – Дэлхийн худалдааны байгууллага

МУ- Монгол Улс

МЭГ- Монополын эсрэг газар

НҮБ – Нэгдсэн Үндэсний Байгууллага

ОУ – Олон улс

ОУХЭЗК (UNCITRAL) – Олон улсын худалдааны эрх зүйн нэгдсэн үндэстний комисс (United Nations Commission On International Trade Law)

ОУСТС (IFRS) - Олон улсын санхүүгийн тайлангийн стандарт ([International Financial Reporting Standards](#))

СЯ – Сангийн Яам

ТХ – Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтэс

ТБОНӨХБАҮХАТ – Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль

ТХАА – Төрийн худалдан авах ажиллагаа

УИХ – Улсын Их Хурал

УССГХ – Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтэс

ХШДШХ – Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс

ФАТФ (FATF) - Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (Financial Action Task Force)

НЭГ. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО

Энэ бүлэгт судалгааны ажлыг хийх үндэслэл, зорилго зорилтын талаар дурдлаа.

1.1 Судалгааны ажлын үндэслэл

Авлигатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасны дагуу авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага юм.

Мөн:

- ✓ Авлигын эсрэг хууль¹-ийн 6 дугаар зүйл “Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа”-ийн 6.1.12 “бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ авах”,
- ✓ “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030он)”²-ийн Зорилт 7.4 “Худалдан авах ажиллагааг хэрэгцээ, шаардлагад үндэслэн төлөвлөх, хяналт тавих, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгоно”-ын 7.4.5 “Төрийн худалдан авах ажиллагааны гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зохицуулалтыг тусгах, зөрчил тогтоогдсон тохиолдолд гэрээг цуцалж, учирсан хохирлыг нөхөн төлүүлж, олон нийтэд мэдээлнэ” гэж заажээ.

1.2 Судалгааны ажлын зорилго

Дээрх хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2030он)³-ний Зорилт 7.4.1.1 “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх”;
- Авлигатай тэмцэх газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний “Хоёрдугаар хэсэг. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ”-ний 2.1.1.16⁴ Судалгаа шинжилгээний албаны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.1.16 дугаар арга хэмжээнд тусгагдсан “Төрийн байгууллагаас 2020-2023 онд зарласан худалдан авах ажиллагаан дахь авлигын нөхцөл байдлыг тодорхойлж, эрсдэлийн дүн шинжилгээ хийх” гэсэн төлөвлөлтийн биелэлтийг хангахад шаардлагатай мэдээллийг нэгтгэн боловсруулж, дүн шинжилгээ хийх, цаашид үйл ажиллагааны төлөвлөлтөд ашиглагдах эх сурвалжийг бий болгоход судалгааны зорилго оршино.

¹ Авлигын эсрэг хууль, 2006 оны 07 дугаар сарын 6-ны өдөр батлагдсан.

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=8928>

² Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030он), УИХ-ын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 59 дугаар тогтоолоор батлагдсан.

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760139781851>

³ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2030 он), УИХ-ын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 46 дугаар тогтоолоор батлагдсан.

⁴ Авлигатай тэмцэх газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө

<https://iaac.mn/post/153155>

ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Энэ бүлэгт судалгааны хамрах хүрээ, судалгааны зохион байгуулалт болон судалгааг хийхэд баримталсан зарчмын талаар дурдлаа.

2.1 Судалгааны хамрах хүрээ

Энэхүү судалгаанд төрийн байгууллагаас 2020-2023 онд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн үр дагаврыг харьцуулан, судалж дүн шинжилгээ хийсэн.

Судалгаанд:

- ✓ Авлигатай тэмцэх газрын албан хэрэг хөтлөлтийн “smart office” цахим системд 2020-2023 онд бүртгэгдсэн өргөдөл, гомдол, мэдээллийн хөтлөлт, шийдвэрлэлтийн статистик тоо;
- ✓ Сангийн Яамны Хууль эрх зүйн газрын Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэст төрийн худалдан авах ажиллагаанд оролцогчдоос 2020-2023 онд гаргасан гомдлын статистик тоо, тайлан мэдээлэл;
- ✓ Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн худалдан авах ажиллагааны газрын цахим портал tender.gov.mn системд 2020-2023 онд хөтлөгдсөн тендер, худалдан авах ажиллагааны дата мэдээлэл;
- ✓ Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Монополын эсрэг газар (Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар)-т 2022-2023 онд төрийн худалдан авах ажиллагаанд оролцогчдоос гаргасан гомдлын статистик тоо, тайлан мэдээллийг нэгтгэн боловсруулж, харьцуулсан.

2.2 Судалгааны арга зүй

Судалгааг төрийн байгууллагаас 2020-2023 онд төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулсан худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн талаар хамрах хүрээнд дурдсан эх үүсвэрээс:

- Мэдээлэл цуглуулж түүврийн болон загварчлах аргаар;
- Боловсруулалт хийж, анализ болон синтезийн аргаар харьцуулан судаллаа.

2.3 Судалгааг хийхэд баримталсан зарчим

Бид судалгааны ажлыг хийж гүйцэтгэхдээ дараах зарчмыг баримтлан ажилласан.



ГУРАВ. ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Энэ бүлэгт төрийн худалдан авах ажиллагааны талаарх ойлголт, тодорхойлолт, төрийн худалдан авах ажиллагаан дахь авлигын нөлөөллийн талаар судлагдсан байдлыг зохих эх сурвалжуудаас судалж, судалгааны ажлын сэдвээр ерөнхий мэдээллийг орууллаа.

Төрийн худалдан авах ажиллагааны тогтолцооны зорилго нь төсвийн хөрөнгийг ил тод, үр ашигтай, шударга зарцуулах замаар төрийн худалдан авалтын үнэ цэнийг бий болгоход орших бөгөөд түүний оновчтой эсэх нь худалдан авалтын үнэ цэнэ, үр дүнг хүртэх олон нийтийн сэтгэл ханамжаар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл, төрийн худалдан авалт нь зөвхөн олон нийтэд бараа, ажил, үйлчилгээг хүргэх төдийгүй тэдний амьдрал, ахуй нөхцөлийг сайжруулах, нийгмийн анги давхаргын тэгш байдлыг хангах, хүн амын амьжиргааны түвшинг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах төрийн бодлогын хэрэгсэл⁵ юм.

Дэлхийн улс орнууд 1990-ээд оноос төрийн худалдан авах ажиллагаанд “бага зардлаар ихийг хийх” (IPPC7, 2016)⁶ буюу төсвийн зардлын хязгаарлалтад нийцсэн үр ашигтай, оновчтой, зөв сонголтыг тэгш өрсөлдөөний зарчмаар хийх шаардлагатай болсон тэр үеэс илүү өргөн хүрээнд судлах болжээ.

Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудад төрийн худалдан авах ажиллагааны тогтолцооны үндэс суурь нь өрсөлдөөний журам, түүнийг хангах гол арга нь өрсөлдөөнт тендер зохион байгуулахаар зохицуулагдсан байдаг тул ДХБ болон НҮБ-аас бусад улс орнуудад энэ жишгээр төрийн худалдан авах ажиллагааны тогтолцоогоо зохион байгуулах нь хамгийн үр дүнтэй гэж үзэж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхийг зөвлөдөг байна. Энэ зөвлөмжийн хүрээнд НҮБ-ын ОУХЭЗК (UNCITRAL)-аас 1994 оны 6-р сарын 15-ны өдөр Худалдан авах ажиллагааны загвар хуулийг⁷ гаргасан нь олон улсад төрийн худалдан авах ажиллагааны загвар хууль болон хэрэглэгдэж, түүнийг өөрийн үндэсний онцлогт нийцүүлэн зохицуулалтын актууд батлан гаргадаг байна.

Төрийн худалдан авах ажиллагааны тогтолцооны оновчтой эсэх нь:

1. эдийн засгийн хувьд төр төрийн худалдан авалтыг хамгийн бага зардлаар одоогийн мөнгөний ирээдүйн үнэ цэнийг хэр урт хугацаанд бий болгосноор,
2. хууль зүйн хувьд төр төрийн худалдан авалтыг тэгш өрсөлдөөнийг хангаж, ил тод зохион байгуулснаар тодорхойлогдоно.

Энэ нь төрийн худалдан авах ажиллагааны зардлын хэмжээ нь асар их учраас сайн засаглалтай төрийн худалдан авалт нь төрийн байгууллагын үр ашгийг дээшлүүлэх, иргэдийн итгэлийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг төдийгүй төрийн бодлогыг хэрэгжүүлэх хэрэгсэл, эдийн засгийн өсөлтийг дэмжих хөшүүрэг болдогтой холбоотой.

⁵ Robert Agwot Komakech “Public Procurement in Developing Countries: Objectives, Principles and Required Professional Skills”, Uganda (East Africa) 2016.

⁶ Public Administration, Governance and Globalization, “Global Public Procurement Theories and Practices”, Khi V. Thai Editor, (IPPC7, 2016), p 1.

International Public Procurement Conference (IPPC7) нь 2016 онд АНУ-ын Washington, DC-д зохион байгуулагдсан. Энэ хурал нь олон улсын худалдан авалтын ил тод байдал, шударга байдлыг хангахад чиглэгдсэн стандартууд, зохицуулалтууд, туршлагаудыг хуваалцах, хамтын ажиллагаа хөгжүүлэх зорилготой зохион байгуулагддаг.

⁷ UNCITRAL-ийн Бараа (ажил), үйлчилгээ худалдан авах тухай загвар хууль (UNCITRAL 1994 оны 6-р сарын 15-нд баталсан) // НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс. Жилийн дэвтэр. 1994 он Т. XXV. Нью-Йорк: НҮБ, 1996. хуудас 417-440.

3.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн талаар

Манай улс “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, гэрээ байгуулах, тайлагнах, хяналт тавих, гомдол шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилго”-оор:

1. УИХ-ын 2000 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн чуулганаар “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгох журмын тухай хууль”-ийг баталж, баталсан өдрөөс;

2. УИХ-ын 2005 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн чуулганаар “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийг баталж, 2006 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс;

3. УИХ-ын 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн чуулганаар “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/” баталж, 2024 оны 01 сарын 01-ний өдрөөс үйл ажиллагаанд мөрдөж эхэлсэн байна. хэрэгжүүлсэн. Мөн төрийн худалдан авалтын цахим систем⁸-ийг бий болгон, төрийн худалдан авах ажиллагааг худалдан авалтын tender.gov.mn цахим форталаар гүйцэтгэж байна.

Хууль хэрэгжиж эхэлсэн 24 жилийн хугацаанд 2 удаа шинэчлэн найруулж, нийт 32 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж тасралтгүй сайжруулалтыг хийсээр байгаа хэдий ч 2024 оны УИХ-ын намрын чуулганаар дахин нэмэлт өөрчлөлт оруулахаар хэлэлцэж байна.

Хэдийгээр эдгээр өөрчлөлтүүд нь төрийн болон орон нутгийн өмч болох хязгаарлагдмал нөөц баялгийг үр ашигтай зарцуулах, хэмнэлтэйгээр худалдан авалт хийх, тендерт оролцогчийн өрсөлдөх тэгш боломжийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжил, төсвийн болон бусад олон хуулийн зохицуулалттай уялдуулан нийцүүлэх шаардлагад үндэслэн эрх зүйн хэм хэмжээг боловсронгуй болох шаардлагатай хэдий ч богино хугацаанд олон дахин өөрчлөлт хийх нь түүний тогтвортой байх шинжийг алдагдуулж, урт хугацаанд түүний үр нөлөө хадгалагдах байдлыг алдагдуулах сөрөг талтай⁹ байдаг тул цаашид практик судалгаанд суурилсан оновчтой, зөв өөрчлөлтийг хийж хуулийн тогтвортой байх шинжийг хадгалах нь чухал юм.

3.2. Төрийн худалдан авах ажиллагаан дахь авлигын талаар

Төрийн худалдан авалтын үнэ өндөр, хэмжээ нь их байдаг тул авлига, тохиролцоо, хүсээгүй ашиг сонирхолтой төрд нөлөө бүхий улс төрчид, төрийн эрх мэдэл бүхий албан тушаалтнуудын хамаарал бүхий бизнес эрхлэгчид, хувийн хэвшил, аж ахуйн нэгжүүдийн ашиг сонирхол их байдаг. Тийм учраас төрийн худалдан авалт нөлөөлөлд өртөмтгий байдаг.

Төрийн худалдан авалтад авлига байсаар байгаа нь төсвийн зардлын багагүй хувийг буюу “дэлхийн хэмжээнд засгийн газар /төсвийн зарлага/-ын жилийн зардлын

⁸ Төрийн худалдан авалтын цахим систем, <https://www.tender.gov.mn/mn/index/>, 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдөр нэвтэрсэн.

⁹ УИХ-ын Тамгын газар “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн тайлан”, 2021.

50 хүртэлх хувь”¹⁰-тай тэнцэх хэмжээний мөнгийг зарцуулдагтай холбоотой бөгөөд төрийн худалдан авалт дахь авлига нь “тухайн төслийн зардлын 10-30 хувийг эзэлдэг”¹¹ болох тухай ДБ судалгаанд дурджээ.

Түүнчлэн, төрийн худалдан авах ажиллагааг ямар ч луйвар, авлигагүйгээр явуулах нь түүнд зарцуулагдаж байгаа мөнгөний үнэ цэнийг цаг хугацааны хувьд тогтворжуулж, хэрэгжилтээс хүртэх үр дүнг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

НҮБ-ын судалгаагаар дэлхийн хэмжээнд авлигын хохирол дэлхийн ДНБ-ний 5%-тай тэнцэж байгаа бөгөөд энэ нь 2023 оны дэлхийн ДНБ 105.44¹² их наяд ам.долларын 5.1 их наяд ам.доллартай тэнцэж байгаа нь:

- эдийн засгийн үзүүлэлтээрээ дэлхийд дөрөвт¹³ эрэмбэлэгдэг Япон улсын жилийн ДНБ-ээс 18% өндөр,
- манай улсын¹⁴ ДНБ-ээс 256 дахин их дүнтэй үзүүлэлт юм.¹⁵

Төрийн худалдан авах ажиллагаа авлигаас ангид явагдахгүй байгаа нь:

1. Төрд төвлөрсөн их хэмжээний мөнгө төрөөс эрх олгосон байдлаар зарцуулагдахад бэлэн байдаг (төсөвлөгддөг);
2. Худалдан авах ажиллагааг хариуцан хийдэг төрийн байгууллагууд (захиалагч) нь арилжааны бус буюу ашиг олох үйл ажиллагаа явуулдаггүй субъектүүд байдаг;
3. Төрийн албан тушаалтны эрх мэдлээр тухайн худалдан авалтын үйл ажиллагаа шийдэгдэж явагддаг. Тухайлбал, ямар этгээдийг тендерт урихаа шийдэх, тухайн компанид ашигтай үнэлгээний шалгуурыг боловсруулах, гэрээ байгуулах үйл явцыг удирдан чиглүүлэх зэргээр албан тушаалын эрх мэдлээ зүй бусаар ашиглах боломжтой байдаг¹⁶-тай холбоотой.

3.3. Монгол Улсын төрийн худалдан авах ажиллагааны зардлын талаар

Төрийн худалдан авах ажиллагаа нь дотоодын эрэлт, нийлүүлэлтийн хэрэгцээг хангахад чиглэгдсэн чиг үүргээс хальж, олон нийтийн үнэ цэнийг хамтран бүтээх төрийн бодлогын хэрэгсэл болтлоо хөгжсөн нь эдийн засагт нэн чухал ач холбогдолтой гэдгийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, эрдэмтэн, судлаачид асуудлын оновчтой онол, практик туршлагад дүн шинжилгээ хийх замаар улам нарийвчлан хөгжүүлж байна. Учир нь:

1. Төрийн худалдан авалт нь төсвийн зардлын ихэнх хувийг эзэлдэг. (Хүснэгт 2)

¹⁰ НҮБ-ийн тайлан. Cause of corruption in public procurement, According to Ferguson (2018)

<https://www.unodc.org/e4j/zh/anti-corruption/module-4/key-issues/corruption-in-public-procurement.html>

¹¹ Public Infrastructure, <https://thedocs.worldbank.org/en/doc/911661611783412604-0090022021/original/PublicInfrastructure.pdf>

Дэлхийн банк нь олон улсын стандарт, аргачлал дээр үндэслэн мэдээллийг боловсруулж, улс орнуудаас хараат бусаар бие даан үйл ажиллагаа явуулаг. Эдгээр шалтгаанаар Дэлхийн банкны мэдээллийг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн, найдвартай эх сурвалж гэж үзэж судлаачид судалгааны эх сурвалж болгон ашигладаг.

¹² Дэлхийн банкны нээлттэй мэдээллээс, <https://data.worldbank.org/indicator/NY.GDP.MKTP.CD>

¹³ GDP (million US\$) by country Japan GDP = 4,212 millions dollar.

¹⁴ GDP (million US\$) by country Mongolia GDP = 0,019 millions dollar.

¹⁵ Global Infrastructure Anti-Corruption Centre, <https://giaccentre.org/the-cost-of-corruption/>

¹⁶ Corruption in public procurement, March 2017, Vienna,

2. Төрийн худалдан авалтад татвар төлөгчдийн мөнгийг зарцуулдаг. (Хүснэгт 3)
3. Төрийн худалдан авалтын үр дүнг зөвхөн харилцаанд оролцогч хоёр тал биш нийтээрээ хүртдэгт оршино.

Олон улсын төрийн худалдан авах ажиллагааны бага хурал (IPPC8)¹⁷-д оролцогч судлаачдын тооцоолсноор дэлхийн улсууд ДНБ-нийхээ 5.15% - 20.18% -ийг төрийн худалдан авалтад¹⁸ зарцуулдаг бөгөөд тооцсон ДНБ-д эзлэх дундаж хувь 13.11% байна.

ДБ-аас тооцоолсноор манай улсын ДНБ 2023 онд 19,872.18 сая америк доллар буюу 67,777,846.86 сая төгрөг байсан бөгөөд тооцоолсон дунджаар ДНБ-нийхээ 13.11 хувийг төрийн худалдан авах ажиллагаанд зарцуулсан гэж тооцвол 8,885,675.72 сая төгрөг буюу 2,605.24 сая доллар зарцуулсан байна.

Хүснэгт 1. МУ-ын ДНБ, түүнээс тооцоолсон дунджаар ТХАА-нд зарцуулсан дүн (2020-2023он, ДБ-ны эх сурвалжаас)

Он	Монгол Улсын ДНБ			ДНБ-ээс ТХАА-нд зарцуулсан дүн		
	сая доллараар ¹⁹	он бүрийн 12 сарын 31-ний өдрийн албан ханш ²⁰	сая төгрөгөөр	дундаж хувь	сая доллараар	сая төгрөгөөр
	1	2	3=1*2	4	5=1*4	6=3*4
2020	13,312.98	2,849.89	37,940,532.64	13.11%	1,745.33	4,974,003.83
2021	15,286.44	2,849.34	43,556,269.90	13.11%	2,004.05	5,710,226.98
2022	17,146.47	3,444.60	59,062,736.46	13.11%	2,247.90	7,743,124.75
2023	19,872.18	3,410.69	67,777,846.86	13.11%	2,605.24	8,885,675.72

Судалгааны өмнөх хэсэгт дэлхийн улс орнууд төрийн худалдан авах ажиллагаанд төсвийн зардлын 50 хувийг зарцуулдаг талаар дурдсан бөгөөд манай улсын хувьд энэ нь:

Хүснэгт 2. МУ-ын төсвийн зарлагын хэмжээ ба ТХАА-ны зардлын зарцуулалт

Он	Төсвийн зарлагын хэмжээ (сая төгрөг)	ТХАА-нд зарцуулсан	
		Судлаачийн тооцсон дүн (сая төгрөг)	Хувь
-	1	2	3 = 2 / 1
2020 ²¹	11,653,262.0	4,974,003.8	43%
2021 ²²	12,568,721.8	5,710,226.9	45%
2022 ²³	11,599,233.6	7,743,124.8	67%

¹⁷ International Public Procurement Conference-8 нь 2021 оны 9 сарын 7-наас 9-ний өдөр хооронд Нидерланд улсын Амстердам хотод зохион байгуулагдсан байна.

¹⁸ Тооцооллын дэлгэрэнгүйг судалгааны хавсралт хэсгээс үзнэ үү.

¹⁹ <https://databank.worldbank.org/reports.aspx?source=2&series=NY.GDP.MKTP.CD&country=MNG>

²⁰ <https://www.mongolbank.mn/mn/currency-rate>

²¹ МУ-ын 2020 оны төсвийн тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14829>

²² МУ-ын 2021 оны төсвийн тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail/15726>

²³ МУ-ын 2022 оны төсвийн тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16381595772311>

Он	Төсвийн зарлагын хэмжээ (сая төгрөг)	ТХАА-нд зарцуулсан	
		Судлаачийн тооцсон дүн (сая төгрөг)	Хувь
-	1	2	3 = 2 / 1
2023 ²⁴	16,949,914.6	8,885,675.7	52%

МУ-ын 2023 оны Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлд “МУ-ын төсвөөс 2023 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээ 16,949,914.6 сая төгрөг байна”²⁵ гэснээс тооцоолоход, нийт төсвийн 52 хувийг төрийн худалдан авах ажиллагаанд зарцуулсан байна.

Төрийн худалдан авах ажиллагааны зөв тогтолцооны хамгийн сайн хэмжүүр нь “татвар төлөгчдийн мөнгийг үр ашигтай, хариуцлагатай, шударга байдлаар зарцуулах”²⁶ гэдэгтэй судлаачид санал нэгтэй байдаг.

Хүснэгт 3. МУ-ын тэнцвэржүүлсэн орлогоос болон татвар татварын орлогын ТХАА-нд зарцуулсан байдал

(сая төгрөг)

Он	Тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ	Үүнээс, ТЕГ-ын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ	ТХАА-нд зарцуулсан судлаачийн тооцсон дүн	Тэнцвэржүүлсэн орлогын хэмжээнээс ТХАА-нд зарцуулсан хувь	ТХАА-ны зарцуулалтад татварын орлогын эзлэх хувь
-	1	2	3	4 = 3 / 1	5 = 2 / 3
2020	7,476,531.2	4,258,824.6	4,974,003.8	67%	86%
2021	9,091,778.2	5,160,920.0	5,710,227.0	63%	90%
2022	9,218,176.2	4,468,940.1	7,743,124.8	84%	58%
2023	15,184,583.6	7,710,317.6	8,885,675.7	59%	87%

МУ-ын 2023 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлогод татварын орлогоос төвлөрүүлэхээр тооцсон 7,710,317.6 сая төгрөг нь төрийн худалдан авах ажиллагаанд зарцуулахаар тооцсон 8,885,675.72 сая төгрөгийн 87 хувьтай тэнцэж байна. Иймд ард түмний татварын орлогоос бүрдүүлсэн улсын төсвийн хөрөнгийн зарцуулалтыг зөв зохистой эрсдэл багатай удирдан зохин байгуулах нь төрийн худалдан авах ажиллагааны үр дүн, үнэ цэнийг улам илүү сайжруулах ёстойг илэрхийлнэ.

3.4 Төрийн худалдан авах ажиллагааг авлигаас ангид явуулах нь

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь “Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаар байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд”²⁷ юм. Төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээд, төрийн байгууллага, албан газарт улсын төсвөөс олгосон хөрөнгийг МУ-ын Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж тайлагнахыг эрхийг олгосон байдаг. Эдгээр төрийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудад олгох улсын төсвийн хөрөнгийн

²⁴ МУ-ын 2023 оны төсвийн тухай хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532001935011>

²⁵ Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль.

²⁶ Tania Ghossein, Asif Mohammed Islam and Federica Saliola (2018), In “Public Procurement and the Private Business Sector: Evidence from Firm-Level Data,”

²⁷ Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, 13-14 дүгээр зүйл.

тодорхой хувийг иргэд, аж ахуйн нэгжээс хураан авч буй татварын орлого бүрдүүлдэг болохыг судалгааны өмнөх хэсэгт харуулсан.

Иймд бид татвар төлөгчдийн татварын орлогоос бүрдүүлсэн “төсөв”²⁸-ийн хөрөнгийн зарцуулалтын ил тод, шударга байдлыг хянах, шаардах, алдаа, луйвар, авлигыг таслан зогсоох арга замыг тодорхойлох нь нэн чухал асуудал юм.

Төрийн худалдан авах ажиллагаа нь:

- илүү өргөн хүрээний оролцогч талууд болох төр, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид, ард иргэд, үйлчлүүлэгчид, үйлчилгээний ашиг хүртэгчид, татвар төлөгчид, олон нийтийн хүссэн үр дүнд хүрэхэд авлигаас ангид байх ёстой;
- ёс зүй, нийгмийн тогтвортой байдал, байгаль орчныг хамгаалах гэх мэт Үндсэн хуульт ёсны үнэт зүйлсэд чиглэсэн үр дүнд хүрэхийн тулд ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх ёстой;
- төр нийтийг засагладаг гэдэг утгаараа худалдан авалт нь илүү өргөн хүрээтэй байж, ард түмэнд нийтээр тэгш боломжийг олгосон байх ёстой.²⁹

Иймд төсвийн хөрөнгийн үр ашигтай зарцуулалтыг хангахад төрийн худалдан авах ажиллагаа чухал үүрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрч, төрийн бодлогод суурилсан чанар, үнэ цэнийг хамгийн сайн хангасан өрсөлдөөний тэгш нөхцөлтэй, үйл ажиллагааны процесс бүрийг маш сайн хуульчилсан боловч хуулийн зорилгод үйл ажиллагаа нь хүрч чадахгүй байна.

Энэ нь төрийн худалдан авах ажиллагааг зохион байгуулагчийн хамгийн бага үнээр төрийн худалдан авах ажиллагаанд оролцох талаа олж авч, хамгийн өндөр үнийг төлөх гэсэн ашиг сонирхлын амин ч үзлээр хязгаарлагдаж байна. Энэ үүргийн гажуудал, үнийн зөрүү нь “Авлига” юм.

“Авлига” гэж олон тодорхойлолтыг иш татаж болох ч эцсийн дүндээ хувьдаа ашиг хүртэх гэсэн хувь хүний санаатай (үйлдэл, эс үйлдэхүйгээр илэрнэ) шууд холбогддог.

Өнөө үед дэлхий нийтээр “Авлига” гэдэг нэр томъёонд тодорхойлолт өгөхөөс татгалзаж, харин авлигын янз бүрийн үйлдлийг хахууль өгөх, хахууль авах (хахууль=шан, харамж, бэлэг, урамшуулал өгөх, авах гэх мэт), хөрөнгө шамшигдуулах, өөрт олгосон эрх мэдлээ хэтрүүлэх, эрх мэдлээ ашиглах гэх зэрэг үйлдлээр нь эрүүгийн гэмт хэрэг гэж тодорхойлж³⁰ байх ба хэлбэрээсээ хамаарч төрийн байгууллага төдийгүй төрөл бүрийн салбарт өөр өөр хэлбэрээр илэрч байгааг судлаачид онцолжээ. Жишээлбэл, төрийн худалдан авалтын шударга бус байдал нь авлигад хүргэдэг бол энэ нь хахууль, хөнгөвчлөх төлбөр, тохиролцоо зэрэг хэд хэдэн үйлдлээр тодорхойлогддог; ашиг сонирхлын зөрчлийн журмыг зөрчих, тендер будилаантуулах, нөлөөллийн наймаа хийх гэх мэт. Хахуулийн хувьд татвар хураах, шүүх эрх мэдэл, нийтийн аж ахуй зэрэг төрийн бусад салбартай

²⁸ Монгол Улсын төсвийн тухай хууль, 4 дүгээр зүйлийн 4.1.5 “төсөв” гэж төрийн болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг.

²⁹ BRAC University, Md. Mahraj Hossain, Degree of Masters “Getting Value for Money from Public Procurement”, January, 2015

³⁰ UNODC, Module Series on Anti-Corruption “Module 4. Public Sector Corruption”,

<https://www.unodc.org/e4j/zh/anti-corruption/module-4/key-issues/corruption-in-public-procurement.html>

харьцуулахад “Төрийн худалдан авах ажиллагааны гэрээ” нь авлигад илүү өртөмтгий гэж үздэг.³¹

Төрийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж буй олон улсын туршлагаас харахад төрийн худалдан авалтыг зохион байгуулах үндэс нь өрсөлдөөнт орчин, ил тод байдал, мэдээллийн хүртээмж, түүнчлэн төрийн болон олон нийтийн давхар хяналт бүхий орчин үеийн мэдээлэл, харилцаа холбооны технологийн чадавхад суурилсан тендер сонгон шалгаруулалтын арга юм.

Ил тод байдал нь ерөнхийдөө худалдан авах ажиллагааны мэдээллийн хүртээмж³² энэ нь тендерт оролцогчдод тендерт оролцоход ижил тэгш нөхцөлөөр бий болгож³³ чадсан эсэхээр илэрхийлэгддэг. Тендер сонгон шалгаруулалт нь ил тод байхын хэрээр энэ нь төрийн зохицуулалтын хэм хэмжээг дагаж мөрдөхөд түлхэц болж, улмаар төрийн худалдан авалт дахь авлигыг багасгах болно³⁴ гэж үздэг байна.

Иймд цаашид төрийн худалдан авах ажиллагаан дахь авлигын эрсдэлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаанд ашиглагдах эх сурвалж бий болгохоор энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэлээ.

ДӨРӨВ. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАРТ 2020–2023 ОНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН СУДАЛГАА

4.1. Өргөдөл, гомдол, мэдээллийн тоо, хүлээн авсан хэлбэр

АТГ-т төрийн худалдан авах ажиллагаатай холбоотой гаргасан гомдол, мэдээллийн тоо 2020 онд 209 байсан бол 2023 онд 372 болж 75%-иар өссөн бөгөөд нийт 2020-2023 онд 1,073 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 4. АТГ-т 2020-2023 онд хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээллийн тоо

№	Шийдвэрлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2020-2023 он
1	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх	55	82	81	111	329
2	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах	30	49	49	50	178
3	Зөрчил илрээгүй тул хаасан	42	27	37	59	165
4	Судалгаанд	26	20	31	59	136
5	(blank)	17	18	17	20	72
6	Бусад төрийн байгууллагад шилжүүлсэн	21		13	6	40
7	Харьяаллын дагуу шилжүүлэх	1	26	1	5	33

³¹ OECD, ‘Government at a Glance 2009’, Online. <http://dx.doi.org/10.1787/724227300453>


³² Georgieva, I. (2017). *Using Transparency Against Corruption in Public Procurement*. Cham: Springer International Publishing. doi:10.1007/978-3-319-51304-1.

³³ Buijze, A. (2013). *The principle of transparency in EU law*. Uitgeverij BOXPress.

³⁴ Public Procurement in the European Union: Transparent and Fair?, Berlin 2022 – Working Paper 65

№	Шийдвэрлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2020-2023 он
8	Авлигатай тэмцэх газрын бусад нэгжид шилжүүлсэн			4	29	33
9	Зөрчлийг тогтоож шийдвэрлэсэн	8	5	7	10	30
10	Хариу өгч буцаасан	4	6	5	7	22
11	Бусад	1	5	4	8	18
12	Харьяаллын бус	2		1	5	8
13	Нэгтгэн шалгасан	2	2		2	6
14	Мөрдөн байцаалтын хэрэг нээх			1	1	2
15	Тогтоогдоогүй			1		1
Нийт		209	240	252	372	1073
Он		2020	2021/2020	2022/2021	2023/2022	2020/2023
Өсөлтийн хувь		100%	+15%	+5%	+48%	+75%

Зураг 1. АТГ-т 2020-2023 онд хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээллийн өсөлт




Иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдээс 2020-2023 онд хүлээн авч шийдвэрлэсэн нийт 1,073 өргөдөл, гомдол, мэдээллийг гаргасан хэлбэрийн хувьд авч үзвэл 542 буюу 50.5% нь, бичгээр, 186 буюу 17.3% нь АТГ-т биечлэн ирж, мэдээлэл хүлээн авах 110 тусгай дугаарт 207 буюу 19.3% нь утсаар, 135 буюу 12.6% нь цахимаар, 3 буюу 0.3% нь бусад хэлбэрээр ирүүлсэн байна.

Хүснэгт 5. Өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авсан хэлбэр 2020-2023 он

Он	Бичгээр		Биечлэн		Утас		Цахим		Бусад		Нийт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
2020	117	56.0%	44	21.1%	27	12.9%	21	10.0%			209	19%
2021	145	60.4%	34	14.2%	27	11.3%	34	14.2%			240	22%
2022	124	49.2%	37	14.7%	58	23.0%	31	12.3%	2	0.8%	252	23%
2023	156	41.9%	71	19.1%	95	25.5%	49	13.2%	1	0.3%	372	35%
Дүн	542	50.5%	186	17.3%	207	19.3%	135	12.6%	3	0.3%	1,073	100%

Зураг 2. АТГ-т 2020-2023 онд өргөдөл, гомдол, мэдээлэл гаргасан хэлбэр



АТГ-т иргэн, хуулийн этгээдээс хүлээн авч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, мэдээллийг гаргасан хэлбэр, шийдвэрлэлтийн төрлөөр судалгааны он тус бүрээр дэлгэрэнгүй үзүүлэв.

Хүснэгт 6. Өргөдөл, гомдол, мэдээлэл гаргасан хэлбэр, шийдвэрлэлт 2020 он

№	Шийдвэрлэлт	Бичгээр	Биечлэн	Утас	Цахим	Нийт	
						тоо	хувь
1	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх	43	9	2	1	55	26.3%
2	Зөрчил илрээгүй тул хаасан	21	8	3	10	42	20.1%
3	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах	21	6		3	30	14.4%
4	Судалгаанд	7	2	15	2	26	12.4%
5	Бусад төрийн байгууллагад шилжүүлсэн	8	9	2	2	21	10.0%
6	(blank)	12	4		1	17	8.1%
7	Зөрчлийг тогтоож шийдвэрлэсэн	3	2	1	2	8	3.8%
8	Хариу өгч буцаасан	1	3			4	1.9%
9	Харьяаллын бус			2		2	1.0%
10	Нэгтгэн шалгасан			2		2	1.0%
11	Бусад	1				1	0.5%
12	Харьяаллын дагуу шилжүүлэх		1			1	0.5%
Нийт		117	44	27	21	209	100%
Хувь		56%	21.10%	12.90%	10%	100%	

Хүснэгт 7. Өргөдөл, гомдол, мэдээлэл гаргасан хэлбэр, шийдвэрлэлт 2021 он

№	Шийдвэрлэлт	Бичгээр	Биечлэн	Утас	Цахим	Нийт	
						тоо	хувь
1	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх	68	5	2	7	82	34.2%
2	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах	37	6	4	2	49	20.4%
5	Зөрчил илрээгүй тул хаасан	8	10	2	7	27	11.3%
3	Бусад төрийн байгууллагад шилжүүлсэн	12	4	2	8	26	10.8%
6	Судалгаанд	4		11	5	20	8.3%
4	(blank)	11	3	2	2	18	7.5%
7	Хариу өгч буцаасан	3	2	1		6	2.5%
8	Зөрчлийг тогтоож шийдвэрлэсэн	2	1	1	1	5	2.1%
9	Бусад		3	1	1	5	2.1%
10	Нэгтгэн шалгасан			1	1	2	0.8%
Нийт		145	34	27	34	240	100%
Хувь		60.4%	14.2%	11.3%	14.2%	100%	

Хүснэгт 8. Өргөдөл, гомдол, мэдээлэл гаргасан хэлбэр, шийдвэрлэлт 2022 он

№	Шийдвэрлэлт	Бичгээр	Биечлэн	Утас	Цахим	Нийт	
						тоо	хувь
1	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх	54	11	10	6	81	32.1%
2	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах	30	8	3	8	49	19.4%
3	Зөрчил илрээгүй тул хаасан	10	9	10	8	37	14.7%
4	Судалгаанд	6	1	22	2	31	12.3%
5	(blank)	9	2	1	5	17	6.7%
6	Бусад төрийн байгууллагад шилжүүлсэн	6	2	4	1	13	5.2%
7	Зөрчлийг тогтоож шийдвэрлэсэн	4		3		7	2.8%
8	Хариу өгч буцаасан	2		2	1	5	2.0%
9	Авлигатай тэмцэх газрын бусад нэгжид шилжүүлсэн	1	2		1	4	1.6%
10	Бусад	1		3		4	1.6%
11	Харьяаллын бус	1				1	0.4%

№	Шийдвэрлэлт	Бичгээр	Биечлэн	Утас	Цахим	Нийт	
						тоо	хувь
12	Мөрдөн байцаалтын хэрэг нээх				1	1	0.4%
13	Тогтоогдоогүй		1			1	0.4%
14	Харьяаллын дагуу шилжүүлэх		1			1	0.4%
Нийт		124	37	58	31	252	100%
Хувь		49.2%	14.7%	23.0%	13.1%	100%	

Хүснэгт 9. Өргөдөл, гомдол, мэдээлэл гаргасан хэлбэр, шийдвэрлэлт 2023 он

№	Шийдвэрлэлт	Бичгээр	Биечлэн	Утас	Цахим	Нийт	
						тоо	хувь
1	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх	65	21	14	11	111	29.8%
3	Зөрчил илрээгүй тул хаасан	14	15	24	6	59	15.9%
4	Судалгаанд	14	4	33	8	59	15.9%
2	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах	30	7	8	5	50	13.4%
6	Авлигатай тэмцэх газрын бусад нэгжид шилжүүлсэн	8	9	5	7	29	7.8%
5	(blank)	11	4	1	4	19	5.1%
8	Зөрчлийг тогтоож шийдвэрлэсэн	3	4	1	2	10	2.7%
7	Бусад	3	1	4		8	2.2%
13	Хариу өгч буцаасан	1	3	2	1	7	1.9%
15	Бусад төрийн байгууллагад шилжүүлсэн		1	1	4	6	1.6%
16	Харьяаллын бус		2	1	2	5	1.3%
9	Харьяаллын дагуу шилжүүлэх	3				3	0.8%
10	Харьяаллын дагуу шилжүүлсэн	2				2	0.5%
12	Нэгтгэн шалгасан	1		1		2	0.5%
11	Мөрдөн байцаалтын хэрэг нээх	1				1	0.3%
Нийт		156	71	95	49	372	100%
Хувь		41.9%	19.1%	25.5%	13.5%	100%	

4.2. Өргөдөл, гомдол, мэдээллийн төрөл

АТГ-т 2020-2023 онд төрийн худалдан авах ажиллагаатай холбоотой нийт 1,073 өргөдөл, гомдол, мэдээлэл гаргаснаас 664 буюу 61.9% нь гэмт хэргийн шинжтэй, 325 буюу 30.3% нь ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой, 72 буюу 6.7% нь харьяалалд хамаарахгүй, 11 буюу 1% нь төрийн байгууллагын ёс зүй, хүнд суртал, удирдах ажилтны гаргасан шийдвэртэй холбоотой, 1 буюу 0.1% нь авлигатай тэмцэх газрын албан тушаалтантай холбогдуулан гаргасан байна.

Хүснэгт 10. Өргөдөл, гомдол, мэдээллийн төрөл 2020-2023 он

№	Шийдвэрлэлт	Гэмт хэргийн шинжтэй	Ашиг сонирхлын зөрчил	Харьяалал хамаарахгүй	Ёс зүй, хүнд суртал	АТГ албан тушаалтан	Нийт	
							тоо	хувь
1	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх	329					329	30.7%
2	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах	178					178	16.6%
3	Зөрчил илрээгүй тул хаасан	-	163		2		165	15.4%
4	Судалгаанд	136					136	12.7%
5	(blank)	-	-	72	-	-	72	6.7%
6	Бусад төрийн байгууллагад шилжүүлсэн	-	66		-		66	6.2%
7	Авлигатай тэмцэх газрын бусад нэгжид шилжүүлсэн	-	33		-		33	3.1%
8	Зөрчлийг тогтоож шийдвэрлэсэн	-	27		3		30	2.8%
9	Хариу өгч буцаасан	-	22		-		22	2.1%
10	Бусад	-	14		4	-	18	1.7%
11	Харьяаллын бус	8					8	0.7%
12	Харьяаллын дагуу шилжүүлэх	5			2		7	0.7%
13	Нэгтгэн шалгасан	6					6	0.6%
14	Мөрдөн байцаалтын хэрэг нээх	2					2	0.2%
15	Тогтоогдоогүй	-	-		-	1	1	0.1%

№	Шийдвэрлэлт	Гэмт хэргийн шинжтэй	Ашиг сонирхлын зөрчил	Харьяалал хамаарахгүй	Ёс зүй, хүнд суртал	АТГ албан тушаалтан	Нийт	
							тоо	хувь
Нийт		664	325	72	11	1	1,073	100%
Хувь		61.90%	30.30%	6.70%	1%	0.10%	100%	

АТГ-т иргэн, хуулийн этгээдээс хүлээн авч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, мэдээллийн төрлөөр судалгааны он тус бүрээр дэлгэрэнгүй үзүүлэв.

Хүснэгт 11. Өргөдөл, гомдол, мэдээллийн төрөл 2020 он

№	Шийдвэрлэлт	Гэмт хэргийн шинжтэй	Ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой	Харьяалалд хамаарахгүй	Нийт	
					тоо	хувь
1	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх	55			55	26.3%
2	Зөрчил илрээгүй тул хаасан		42		42	20.1%
3	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах	30			30	14.4%
4	Судалгаанд	26			26	12.4%
5	Бусад төрийн байгууллагад шилжүүлсэн		21		21	10.0%
6	(blank)			17	17	8.1%
7	Зөрчлийг тогтоож шийдвэрлэсэн		8		8	3.8%
8	Хариу өгч буцаасан		4		4	1.9%
9	Нэгтгэн шалгасан	2			2	1.0%
10	Харьяаллын бус	2			2	1.0%
11	Харьяаллын дагуу шилжүүлэх	1			1	0.5%
12	Бусад		1		1	0.5%
Нийт		116	76	17	209	0%
Хувь		56%	36%	8%	100%	

Өргөдөл, гомдол, мэдээллийн төрлөөр нь авч үзэхэд 2020 онд 116 буюу нийт гомдлын 56% нь гэмт хэргийн шинжтэй, 76 буюу нийт гомдлын 36% нь ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой, 17 буюу нийт гомдлын 8% нь харьяалалд хамаарахгүй байна.

Хүснэгт 12. Өргөдөл, гомдол, мэдээллийн төрөл 2021 он

№	Шийдвэрлэлт	Гэмт хэргийн шинжтэй	Ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой	Харьяалалд хамаарахгүй	Ёс зүй, хүнд суртал	Нийт	
						тоо	хувь
1	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх	82				82	34.2%

№	Шийдвэрлэлт	Гэмт хэргийн шинжтэй	Ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой	Харьяалалд хамаарахгүй	Ёс зүй, хүнд суртал	Нийт	
						тоо	хувь
2	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах	49				49	20.4%
3	Зөрчил илрээгүй тул хаасан		27			27	11.3%
4	Бусад төрийн байгууллагад шилжүүлсэн		26			26	10.8%
5	Судалгаанд	20				20	8.3%
6	(blank)			18		18	7.5%
7	Хариу өгч буцаасан		6			6	2.5%
8	Зөрчлийг тогтоож шийдвэрлэсэн		5			5	2.1%
9	Бусад		4		1	5	2.1%
10	Нэгтгэн шалгасан	2				2	0.8%
Нийт		153	68	18	1	240	100%
Хувь		63.8%	28.3%	7.5%	0.4%	100%	

Өргөдөл, гомдол, мэдээллийн төрлөөр нь авч үзэхэд 2021 онд 153 буюу нийт гомдлын 63.8% нь гэмт хэргийн шинжтэй, 68 буюу нийт гомдлын 28.3% нь ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой, 18 буюу нийт гомдлын 7.5% нь харьяалалд хамаарахгүй, 1 буюу 0.4% нь ёс зүй, хүнд суртал холбоотой байна.

Хүснэгт 13. Өргөдөл, гомдол, мэдээллийн төрөл 2022 он

№	Шийдвэрлэлт	Гэмт хэргийн шинжтэй	Ашиг сонирхлын зөрчил	Харьяалалд хамаарахгүй	Ёс зүй, хүнд суртал	АТГ албан тушаалтан	Нийт	
							тоо	хувь
1	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх	81					81	32.1%
2	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах	49					49	19.4%
3	Зөрчил илрээгүй тул хаасан		36		1		37	14.7%
4	Судалгаанд	31					31	12.3%
5	(blank)			17			17	6.7%
6	Бусад төрийн байгууллагад шилжүүлсэн		13				13	5.2%
7	Зөрчлийг тогтоож шийдвэрлэсэн		7				7	2.8%
8	Хариу өгч буцаасан		5				5	2.0%
9	Авлигатай тэмцэх газрын бусад нэгжид шилжүүлсэн		4				4	1.6%

10	Бусад		3		1		4	1.6%
11	Мөрдөн байцаалтын хэрэг нээх	1					1	0.4%
12	Харьяаллын бус	1					1	0.4%
13	Харьяаллын дагуу шилжүүлэх	1					1	0.4%
14	Тогтоогдоогүй					1	1	0.4%
Нийт		164	68	17	2	1	252	100%
Хувь		65.1%	27.0%	6.7%	0.8%	0.4%	100%	

Өргөдөл, гомдол, мэдээллийн төрлөөр нь авч үзэхэд 2022 онд 164 буюу нийт гомдлын 65.1% нь гэмт хэргийн шинжтэй, 68 буюу нийт гомдлын 27% нь ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой, 17 буюу нийт гомдлын 6.7% нь харьяалалд хамаарахгүй, 2 буюу 0.8% нь ёс зүй, хүнд суртал холбоотой, 1 буюу 0.4% нь АТГ-ын ажилтан албан тушаалтанд хамааралтай байна.

Хүснэгт 14. Өргөдөл, гомдол, мэдээллийн төрөл 2023 он

№	Шийдвэрлэлт	Гэмт хэргийн шинжтэй	Ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой	Харьяалалд хамаарахгүй	Ёс зүй, хүнд суртал	ХАСУМ болон ХОМ	Захиргааны шинж чанартай	Нийт	
								тоо	хувь
1	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх	111						111	29.8%
2	Судалгаанд	59						59	15.9%
3	Зөрчил илрээгүй тул хаасан		56		1	2		59	15.9%
4	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах	50						50	13.4%
5	Авлигатай тэмцэх газрын бусад нэгжид шилжүүлсэн		29					29	7.8%
6	(blank)	0		19			1	20	5.4%
7	Зөрчлийг тогтоож шийдвэрлэсэн		7		3			10	2.7%
8	Бусад		6		2			8	2.2%
9	Хариу өгч буцаасан		7					7	1.9%
10	Бусад төрийн байгууллагад шилжүүлсэн		6					6	1.6%
11	Харьяаллын бус	5						5	1.3%
12	Харьяаллын дагуу шилжүүлэх	3						3	0.8%
13	Нэгтгэн шалгасан	2						2	0.5%

14	Харьяаллын дагуу шилжүүлсэн				2			2	0.5%
15	Мөрдөн байцаалтын хэрэг нээх	1						1	0.3%
Нийт		231	111	19	8	2	1	372	100%
Хувь		62.1%	29.8%	5.1%	2.2%	0.5%	0.3%	100%	

Өргөдөл, гомдол, мэдээллийн төрлөөр нь авч үзэхэд 2023 онд 231 буюу нийт гомдлын 62.1% нь гэмт хэргийн шинжтэй, 111 буюу нийт гомдлын 29.8% нь ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой, 19 буюу нийт гомдлын 5.1% нь харьяалалд хамаарахгүй, 8 буюу 2.2% нь ёс зүй, хүнд суртал холбоотой, 2 буюу нийт гомдлын 0.5% нь удирдах ажилтны гаргасан шийдвэртэй холбоотой, 1 буюу нийт гомдлын 0.3% нь ХАСУМ болон ХОМ-той холбоотой байна.

4.3. Өргөдөл, гомдол, мэдээллийн хуваарилалт хэлтэс, албаар

3. Захиалагчийн шийдвэрт гаргасан гомдол 1,009 буюу 79.4% байна.

Хүснэгт 52. СЯ-ны 2020 оны захиалагчийн шийдвэрт гаргасан гомдлын шийдвэрлэлт

№	Шийдвэрлэлт	Тоо	Хувь
1	Тендер шалгаруулалтыг хүчингүй болгох	71	7.0%
2	Үнэлгээг дахин хийх	519	51.4%
3	Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй	134	13.3%
4	Гомдол хүлээн авах боломжгүй, шүүхэд хандах	95	9.4%
5	Гомдлын бүрдүүлбэр дутуу хүлээн авах боломжгүй	89	8.8%
6	Өөр бусад	48	4.8%
7	Гомдлоо эргүүлэн татсан	35	3.5%
8	Хуулийн 55 дугаар зүйлийн 55.2-т заасны дагуу шийдвэрлэж хариу өгсөн асуудлаар дахин гаргасан гомдлыг хүлээн авах боломжгүй	10	1.0%
9	Захиалагчид гомдлоо гаргах	8	0.8%
Нийт захиалагчийн гаргасан шийдвэрт гаргасан гомдол		1,009	100%

³⁹ Сангийн Яам “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын (2020-2023 он)-ны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ хийсэн тухай тайлан”

Судалгааны түүврийн 2020 онд захиалагчийн гаргасан шийдвэрт гаргасан 1,009 гомдлын 71 буюу 7.0% нь тендер шалгаруулалтыг хүчингүй болгож, 519 буюу 51.4% нь тендер шалгаруулалтын үнэлгээг дахин хийх, 134 буюу 13.3% нь захиалагчийн шийдвэр үндэслэлтэй, 95 буюу 9.4% нь гомдол хүлээн авах боломжгүй буюу шүүхэд хандах, 10 буюу 1.0% нь шийдвэрлэсэн асуудлаар дахин гомдол гаргасан тул хүлээн авах боломжгүй, шүүхэд хандах, 89 буюу 8.8% нь гомдлын бүрдүүлбэр дутуу хүлээн авах боломжгүй, 48 буюу 4.6% нь бусад, 35 буюу 3.5% нь гомдлоо эргүүлэн татсан, 8 буюу 0.8% нь захиалагчид гомдол гарах гэж шийдвэрлэгдсэн байна

СЯ-нд 2021 онд нийт 1,207 гомдлыг худалдан авах ажиллагаанд оролцогчоос гаргаснаас:

1. Гэрээ байгуулагдсанаас хойш гаргасан гомдол 75 буюу 6.2%;
2. Тендерийн нээлт хийхээс өмнө гаргасан гомдол 262 буюу 21.7%;
3. Захиалагчийн шийдвэрт гаргасан гомдол 870 буюу 72.1% байна.

Хүснэгт 53. СЯ-ны 2021 оны захиалагчийн шийдвэрт гаргасан гомдлын шийдвэрлэлт

№	Шийдвэрлэсэн байдал	Тоо	Хувь
1	Тендер шалгаруулалтыг хүчингүй болгох	55	6.3%
2	Үнэлгээг дахин хийх	495	56.9%
3	Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй	154	17.7%
4	Гомдол хүлээн авах боломжгүй, шүүхэд хандах	63	7.2%
5	Гомдлоо эргүүлэн татсан	42	4.8%
6	Хуулийн 55 дугаар зүйлийн 55.2-т заасны дагуу шийдвэрлэж хариу өгсөн асуудлаар дахин гаргасан гомдлыг хүлээн авах боломжгүй	43	4.9%
7	Захиалагчид гомдлоо гаргах	13	1.5%
8	Захиалагчийн шийдвэр гараагүй	5	0.6%
Нийт захиалагчийн гаргасан шийдвэрт гаргасан гомдол		870	100%

Судалгааны түүврийн 2021 онд захиалагчийн гаргасан шийдвэрт гаргасан 870 гомдлын 55 буюу 6.3% нь тендер шалгаруулалтыг хүчингүй болгож, 495 буюу 56.4% нь тендер шалгаруулалтын үнэлгээг дахин хийх, 154 буюу 17.7% нь захиалагчийн шийдвэр үндэслэлтэй, 63 буюу 7.2% нь гомдол хүлээн авах боломжгүй буюу шүүхэд хандах, 43 буюу 4.9% шийдвэрлэсэн асуудлаар дахин гомдол гаргасан тул хүлээн авах боломжгүй, шүүхэд хандах, 42 буюу 4.8% нь гомдлоо эргүүлэн татсан, 13 буюу 1.5% нь захиалагчид гомдол гарах, 5 буюу 0.6% нь захиалагчийн шийдвэр гараагүй гэж шийдвэрлэгдсэн байна.

СЯ-нд 2022 онд нийт 1,548 гомдлыг худалдан авах ажиллагаанд оролцогчоос гаргаснаас:

1. Гэрээ байгуулагдсанаас хойш гаргасан гомдол 65 буюу 4.2%;
2. Тендерийн нээлт хийхээс өмнө гаргасан гомдол 184 буюу 11.9%;
3. Захиалагчийн шийдвэрт гаргасан гомдол 1,299 буюу 83.9% байна.

Хүснэгт 54. СЯ-ны 2022 оны захиалагчийн шийдвэрт гаргасан гомдлын шийдвэрлэлт

№	Шийдвэрлэсэн байдал	Тоо	Хувь
1	Тендер шалгаруулалтыг хүчингүй болгох	55	4.2%
2	Үнэлгээг дахин хийх	740	57.0%
3	Гомдлын бүрдүүлбэр дутуу хүлээн авах боломжгүй	153	11.8%
4	Ажлын 5 хоног хэтэрсэн тул гомдол хүлээн авах боломжгүй	65	5.0%
5	Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй	174	13.4%
6	Гомдлоо эргүүлэн татсан	50	3.8%
7	Хуулийн 55 дугаар зүйлийн 55.2-т заасны дагуу шийдвэрлэж хариу өгсөн асуудлаар дахин гаргасан гомдлыг хүлээн авах боломжгүй	44	3.4%
8	Захиалагчид гомдлоо гаргах	12	0.9%
9	Захиалагчийн шийдвэр гараагүй	3	0.2%
10	Гомдол хүлээн авах боломжгүй, шүүхэд хандах	3	0.2%
Нийт захиалагчийн гаргасан шийдвэрт гаргасан гомдол		1,299	100%

Судалгааны түүврийн 2022 онд захиалагчийн гаргасан шийдвэрт гаргасан 1,299 гомдлын 55 буюу 4.2% нь тендер шалгаруулалтыг хүчингүй болгож, 740 буюу 57.0% нь тендер шалгаруулалтын үнэлгээг дахин хийх, 174 буюу 13.4% нь захиалагчийн шийдвэр үндэслэлтэй, 65 буюу 5.0% нь ажлын 5 хоног хэтэрсэн тул гомдол хүлээн авах боломжгүй, шүүхэд хандах, 44 буюу 3.4% нь шийдвэрлэсэн асуудлаар дахин гомдол гаргасан тул хүлээн авах боломжгүй, шүүхэд хандах, 3 буюу 0.2% нь гомдол хүлээн авах боломжгүй, шүүхэд хандах, 153 буюу 11.8% нь гомдлын бүрдүүлбэр дутуу хүлээн авах боломжгүй, 50 буюу 3.8% нь гомдлоо эргүүлэн татсан, 12 буюу 0.9% нь захиалагчид гомдол гарах, 3 буюу 0.2% нь захиалагчийн шийдвэр гараагүй гэж шийдвэрлэгдсэн байна.

СЯ-нд 2023 онд нийт 2,057 гомдлыг худалдан авах ажиллагаанд оролцогчоос гаргаснаас:

1. Гэрээ байгуулагдсанаас хойш гаргасан гомдол 143 буюу 7.0%;
2. Тендерийн нээлт хийхээс өмнө гаргасан гомдол 428 буюу 20.8%;
3. Захиалагчийн шийдвэрт гаргасан гомдол 1,486 буюу 72.2% байна.

Хүснэгт 55. СЯ-ны 2023 оны захиалагчийн шийдвэрт гаргасан гомдлын шийдвэрлэлт

№	Шийдвэрлэсэн байдал	Тоо	Хувь
1	Тендер шалгаруулалтыг хүчингүй болгох	40	1.9%
2	Үнэлгээг дахин хийх	1,054	51.2%
3	Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй	278	13.5%
4	Гомдлын бүрдүүлбэр дутуу хүлээн авах боломжгүй	262	12.7%
5	Гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн /тендерийн баталгаа улсын орлого болгоно/	114	5.5%
6	Өөр бусад	103	5.0%
7	Ажлын 5 хоног хэтэрсэн тул гомдол хүлээн авах боломжгүй	83	4.0%
8	Хуулийн 55 дугаар зүйлийн 55.2-т заасны дагуу шийдвэрлэж хариу өгсөн асуудлаар дахин гаргасан гомдлыг хүлээн авах боломжгүй	60	2.9%
9	Гомдлоо эргүүлэн татсан	51	2.5%

10	Захиалагчид гомдлоо гаргах	10	0.5%
11	Захиалагчийн шийдвэр гараагүй	2	0.1%
Нийт захиалагчийн гаргасан шийдвэрт гаргасан гомдол		2,057	100%

Сангийн Яам “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ хийсэн тухай тайлан” судалгааны түүврийн өмнөх 3 жилийн тайлангаас бичвэрийн болон тайлагналтын хувьд өөр байсан тул тоон утгын харьцуулсан судалгааг хийхэд мэдээлэл дутуу, шууд нэгтгэхэд бэрхшээлтэй байв. Иймд судлаачдын хувьд СЯ-ны холбогдох хэлтсээс ирүүлсэн дата мэдээлэлд үндэслэн шийдвэрлэлтийн дэлгэрэнгүйг боловсруулсан болно.

Судалгааны түүврийн 2023 онд гаргасан нийт 2,057 гомдлын 40 буюу 1.9% нь тендер шалгаруулалтыг хүчингүй болгож, 1,054 буюу 51.2% нь тендер шалгаруулалтын үнэлгээг дахин хийх, 278 буюу 13.5% нь захиалагчийн шийдвэр үндэслэлтэй, 114 буюу 5.5% нь гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн /тендерийн баталгаа улсын орлого болгоно/, 262 буюу 12.7% нь гомдлын бүрдүүлбэр дутуу хүлээн авах боломжгүй, 83 буюу 4.0% нь ажлын 5 хоног хэтэрсэн тул гомдол хүлээн авах боломжгүй, шүүхэд хандах, 60 буюу 2.9% нь шийдвэрлэсэн асуудлаар дахин гомдол гаргасан тул хүлээн авах боломжгүй, шүүхэд хандах, 89 буюу 8.8% нь гомдлын бүрдүүлбэр дутуу хүлээн авах боломжгүй, 103 буюу 5.0% нь бусад, 51 буюу 2.5% нь гомдлоо эргүүлэн татсан, 10 буюу 0.5% нь захиалагчид гомдол гарах, 2 буюу 0.1% нь захиалагчийн шийдвэр гараагүй гэж шийдвэрлэгдсэн байна.

ЗУРГАА. МОНОПОЛЫН ЭСРЭГ ГАЗАРТ 2022–2023 ОНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА

6.1. Монополын эсрэг газарт ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, салбараар

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Монополын эсрэг газар (Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар)-нь энэхүү нэг сэдэвт судалгаанд 2022-2023 оны худалдан авах ажиллагаатай холбоотой тухайн байгууллагад гаргасан гомдол мэдээллийг ирүүлсэн бөгөөд судлаачийн зүгээс өгөгдсөн дата мэдээллийг нэгтгэн боловсруулсан болно.

Хүснэгт 56. МЭГ-т өргөдөл, гомдол гаргагч салбараар

№	Салбар	2022 он		2023 он		Нийт	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1	Уул уурхай	59	25.8%	66	35.9%	125	30.3%
2	Эрүүл мэнд	31	13.5%	23	12.5%	54	13.1%
3	Ахуй үйлчилгээ	30	13.1%	20	10.9%	50	12.1%
4	Барилга, дэд бүтэц	29	12.7%	18	9.8%	47	11.4%
5	Зам тээвэр	24	10.5%	18	9.8%	42	10.2%
6	Бусад	11	4.8%	10	5.4%	21	5.1%
7	Эрчим хүч	14	6.1%	6	3.3%	20	4.8%
8	Мэдээлэл, харилцаа холбоо	7	3.1%	7	3.8%	14	3.4%
9	Боловсрол	4	1.7%	9	4.9%	13	3.1%
10	Банк, даатгал	7	3.1%	6	3.3%	13	3.1%

11	Хүнс, хөдөө аж ахуй	13	5.7%	1	0.5%	14	3.4%
Нийт		229	100%	184	100%	413	100%
Хувь		55.4%		44.6%			100%

Гомдлын агуулгад дурдагдсан асуудлыг салбараар дэлгэрэнгүйг хийхэд хамгийн их гомдолд хамаарах эхний таван салбар бүх онд адилхан байна. Энэ нь:

1. Уул уурхай 125 буюу 30.3%,
2. Эрүүл мэнд 54 буюу 13.1%,
3. Ахуй үйлчилгээ 50 буюу 12.1%,
4. Барилга, дэд бүтэц 47 буюу 11.4%,
5. Зам тээвэр 42 буюу 10.2% байгаа нь нийлбэр дүнгээр 315 буюу 77.1%-тай тэнцүү байгаа нь нийтийн гомдлын 2/3-оос их үзүүлэлттэй юм.

6.2. Монополын эсрэг газарт ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал

Хүснэгт 57. МЭГ-т 2022-2023 онд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

№	Шийдвэрлэсэн байдал	Тоо	Хувь
1	ТБОНӨХБАҮХАТ хууль зөрчсөн	211	51.1%
2	Гомдол гаргах хугацаа хэтэрсэн	106	25.7%
3	Хууль зөрчөөгүй	36	8.7%
4	Тендерийн нээлт хийсэн	18	4.4%
5	Тендерт оролцогч биш	15	3.6%
6	Бүхэлд нь хүчингүй болгосон	8	1.9%
7	Гомдлоо дахин гаргасан	8	1.9%
8	Гомдлоо буцаан татсан	6	1.5%
9	ОУ-ын гэрээгээр зохицуулагдаж байгаа	5	1.2%
Нийт гомдлын тоо		413	100%
Гаргасан шийдвэрт хариу ирүүлсэн		100	24.2%

МЭГ-т 2022-2023 онд 413 аж ахуйн нэгж байгууллага гомдол гаргажээ.

Өргөдөл, гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл ТБОНӨХБАҮХАТ хууль зөрчсөн 211 буюу 51.1%, гомдол гаргах хугацаа хэтэрсэн 106 буюу 25.7%, хууль зөрчөөгүй 36 буюу 8.7%, тендерийн нээлт хийсэн 18 буюу 4.4%, тендерт оролцогч биш 15 буюу 3.6%, бүхэлд нь хүчингүй болгосон 8 буюу 1.9%, гомдлоо дахин гаргасан 8 буюу 1.9%, гомдлоо буцаан татсан 6 буюу 1.5%, ОУ-ын гэрээгээр зохицуулагдаж байгаа 5 буюу 1.2%-тай шийдвэрлэгдсэн байна. Өөрөөр хэлбэл тухайн онд тус газарт гаргасан гомдлын нийт 234 буюу 56.6% дээр зөрчлийг тогтоож шийдвэрлэсэн байна.

МЭГ-ын шийдвэрийн дагуу 100 байгууллага буюу 42.7% нь зөрчлийн дагуу холбогдох арга хэмжээ авч, хариу ирүүлсэн байна.

Хүснэгт 58. МЭГ-ын 2023 оны өргөдөл, гомдол шийдвэрлэлт

№	Шийдвэрлэсэн байдал	Тоо	Хувь
1	ТБОНӨХБАҮХАТ хууль зөрчсөн	128	55.9%
2	Гомдол гаргах хугацаа хэтэрсэн	54	23.6%
3	Хууль зөрчөөгүй	18	7.9%

№	Шийдвэрлэсэн байдал	Тоо	Хувь
4	Тендерийн нээлт хийсэн	10	4.4%
5	Тендерт оролцогч биш	5	2.2%
6	Гомдлоо буцаан татсан	5	2.2%
7	ОУ-ын гэрээгээр зохицуулагдаж байгаа	5	2.2%
8	Бүхэлд нь хүчингүй болгосон	2	0.9%
9	Гомдлоо дахин гаргасан	2	0.9%
Нийт гомдлын тоо		229	100%
Гаргасан шийдвэрт хариу ирүүлсэн		63	48,6%

МЭГ-т 2023 онд гаргасан 229 гомдлыг шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл ТБОНӨХБАҮХАТ хууль зөрчсөн 128 буюу 55.9%, гомдол гаргах хугацаа хэтэрсэн 54 буюу 23.6%, хууль зөрчөөгүй 18 буюу 7.9%, тендерийн нээлт хийсэн 10 буюу 4.4%, тендерт оролцогч биш 5 буюу 2.2%, гомдлоо буцаан татсан 5 буюу 2.2%, ОУ-ын гэрээгээр зохицуулагдаж байгаа 5 буюу 2.2%, бүхэлд нь хүчингүй болгосон 2 буюу 0.9%, гомдлоо дахин гаргасан 2 буюу 0.9%-тай шийдвэрлэгдсэн байна. Өөрөөр хэлбэл тухайн онд тус газарт гаргасан гомдлын нийт 135 буюу 60.0% дээр зөрчлийг тогтоож шийдвэрлэснээс шийдвэрийн дагуу 63 аж ахуйн нэгж буюу 46.7% нь хариу ирүүлж ажилласан байна.

МЭГ-ын 2022 оны гомдол шийдвэрлэлтийн дэлгэрэнгүй:

Хүснэгт 59. МЭГ-ын 2022 оны өргөдөл, гомдол шийдвэрлэлт

№	Шийдвэрлэсэн байдал	Тоо	Хувь
1	ТБОНӨХБАҮХАТ хууль зөрчсөн	83	45.1%
2	Гомдол гаргах хугацаа хэтэрсэн	52	28.3%
3	Хууль зөрчөөгүй	18	9.8%
4	Тендерт оролцогч биш	10	5.4%
5	Тендерийн нээлт хийсэн	8	4.3%
6	Бүхэлд нь хүчингүй болгосон	6	3.3%
7	Гомдлоо дахин гаргасан	6	3.3%
8	Гомдлоо буцаан татсан	1	0.5%
Нийт гомдлын тоо		184	100%
Гаргасан шийдвэрт хариу ирүүлсэн		37	43.5%

МЭГ-т 2022 онд гаргасан 184 гомдлыг шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл шийдвэрлэсэн байдлаар нь авч үзвэл ТБОНӨХБАҮХАТ хууль зөрчсөн 83 буюу 45.1%, гомдол гаргах хугацаа хэтэрсэн 52 буюу 28.3%, хууль зөрчөөгүй 18 буюу 9.8%, тендерт оролцогч биш 10 буюу 5.4%, тендерийн нээлт хийсэн 8 буюу 4.3%, бүхэлд нь хүчингүй болгосон 6 буюу 3.3%, гомдлоо дахин гаргасан 6 буюу 3.3%8 гомдлоо буцаан татсан 1 буюу 0.5%-тай шийдвэрлэгдсэн байна. Өөрөөр хэлбэл тухайн онд тус газарт гаргасан гомдлын нийт 93 буюу нийт 50.5% дээр зөрчлийг тогтоож шийдвэрлэснээс шийдвэрийн дагуу 37 аж ахуйн нэгж буюу 39.8% нь хариу ирүүлж ажилласан байна.

ДҮГНЭЛТ

- ❖ Дэлхий банкнаас төрийн худалдан авах ажиллагаанд хийсэн судалгаагаар төрийн худалдан авалт дахь авлига нь “тухайн төслийн зардлын 10-30 хувийг эзэлдэг”. Судлаачийн тооцоолсон төрийн худалдан авах ажиллагаан дахь авлигын зардалд 10% буюу хамгийн бага дүнгээр зарцуулдаг гэж тооцвол Монгол Улсын хувьд 2020-2023 онд 2,731,303.1 сая төгрөг буюу нийт тухайн жилүүдийн төсвийн зардлын 5%-тай тэнцэж байна.

Хүснэгт 60. Монгол Улсын 2020-2023 оны төсвийн орлого, зарлагын үзүүлэлт
(сая төгрөг)

Он	Тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ	Төсвийн зарлагын хэмжээ	Зөрүү (алдагдал)	ТХАА-нд зарцуулсан судлаачийн тооцсон дүн	Үүнээс: авлигын эрсдэлийг 10% гэж тооцоход
А	1	2	3 = 1 - 2	4	5 = 4*10%
2020	7,476,531.2	11,653,262.0	-4,176,730.8	4,974,003.8	497,400.4
2021	9,091,778.2	12,568,721.8	-3,476,943.6	5,710,227.0	571,022.7
2022	9,218,176.2	11,599,233.6	-2,381,057.4	7,743,124.7	774,312.5
2023	15,184,583.6	16,949,914.6	-1,765,331.0	8,885,675.7	888,567.6
Нийт	40,971,069.2	52,771,132.0	-11,800,062.8	27,313,031.3	2,731,303.1

- ❖ Төрийн худалдан авах ажиллагаан дахь авлигын эрсдэлийг бууруулах зүй зохистой удирдлагыг бий болгох нь төсвийн зарлагын алдагдлыг багасгах улмаар орлогын тэгш хуваарилалтыг бий болгоход чухал үүрэгтэй гэж дүгнэж байна.
- ❖ Авлига нь хөгжилд чиглэсэн хөрөнгийг өөр тийш нь чиглүүлж, Засгийн Газрын үндсэн үйлчилгээ үзүүлэх чадавхыг алдагдуулж, тэгш шударга бус байдлыг өдөөж, гадаадын хөрөнгө оруулалт, тусламжийг үргээх замаар орлого багатай иргэдэд хохирол учруулдаг⁴⁰ болохыг олон улсын судалгаанд дурджээ. Иймд төрийн худалдан авах ажиллагаан дахь авлигын эрсдэлийг бууруулах судалгааны үр дүн, дүгнэлтэд үндэслэсэн саналыг судлаачдын багаас “Санал” хэсэгт дэвшүүллээ.
- ❖ Судалгааны түүврийн хугацаанд Авлигатай тэмцэх газарт төрийн худалдан авах ажиллагаатай холбоотой гаргасан өргөдөл, гомдол, мэдээллийн тоо 2020 онд 209 байсан бол 2023 онд 372 болж 75%-аар өссөн бөгөөд нийт 2020-2023 онд 1,073 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авч шийдвэрлэсэн байна.
- ❖ Нийт 1,073 өргөдөл, гомдол, мэдээллийг бүтцийн нэгжийн чиг үүргийн дагуу:
 - ✚ Авлига, ашиг сонирхлын шинжтэй зөрчил үүссэн байх эрсдэлтэй тул МШХ-т 571 өргөдөл, гомдол, мэдээлэл буюу 53.1%, ГАХ-т 162 буюу 15.1%,
 - ✚ Авлига, ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх тухай шалгуулахаар ХШДШХ-т 325 өргөдөл, гомдол, мэдээлэл буюу 30.2%,
 - ✚ Бусад хэлтэс, албадад 15 буюу 1.4% хуваарилагдан шалгагдсан байна.
- ❖ Дээрх 1,073 өргөдөл, гомдол, мэдээлэл нь агуулгын хувьд:
 - ✚ Гэмт хэргийн шинжтэй 664 буюу 61.9%,
 - ✚ Ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой 325 буюу 30.3%,
 - ✚ Харьяалалд хамаарахгүй 72 буюу 6.7%,

⁴⁰ UNITED NATIONS CONVENTION AGAINST CORRUPTION, Foreword,
https://www.unodc.org/documents/treaties/UNCAC/Publications/Convention/08-50026_E.pdf

- Төрийн байгууллагын ёс зүй, хүнд суртал, удирдах ажилтны гаргасан шийдвэртэй холбоотой 11 буюу 1%,
- АТГ-ын албан тушаалтантай холбогдуулан 1 буюу 0.1%-тай байна.

Хүснэгт 61. МШХ-ийн шийдвэрлэлт

№	Шийдвэрлэлт	Дүн	Хувь
1	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан	178	31.2%
2	Зөрчлийг тогтоосон	2	0.4%
	үүнээс: мөрдөн байцаалтын хэрэг нээх	2	0.4%
3	Бусад	391	68.5%
	үүнээс:		
	хэрэг бүртгэлтийн хэрэг нээх	317	55.5%
	бусад	69	12.1%
	харьяаллын дагуу шилжүүлсэн	5	0.9%
Нийт		571	100%

Хүснэгт 62. ХШДШХ-ийн шийдвэрлэлт

№	Шийдвэрлэлт	Дүн	Хувь
1	Зөрчил илрээгүй тул хаасан	163	50.2%
2	Зөрчлийг тогтоосон	60	18.5%
	үүнээс:		
	тухайн хэлтэс шийдвэрлэсэн	27	8.3%
	АТГ-ын бусад нэгжид шилжүүлсэн	33	10.2%
3	Бусад	102	31.4%
	үүнээс:		
	бусад байгууллагад шилжүүлсэн	66	20.3%
	хариу өгч буцаасан	22	6.8%
	бусад	14	4.3%
Нийт		325	100%

Хүснэгт 63. ГАХ-ийн шийдвэрлэлт

№	Шийдвэрлэлт	Дүн	Хувь
1	Судалгаанд байгаа	136	84.0%
2	Зөрчлийг тогтоосон	18	11.1%
	үүнээс:		
	бүртгэлтийн хэрэг нээх	12	7.4%
	хэрэг нэгтгэн шалгасан	6	3.7%
3	Бусад	8	4.9%
	үүнээс:		
	харьяаллын бус	8	4.9%
Нийт		162	100%

- ❖ Авлигатай тэмцэх газарт 2020-2023 онд төрийн худалдан авах ажиллагаатай холбоотой гаргасан нийт 1,073 өргөдөл, гомдол, мэдээллийг нийслэл болон 21 аймгаар, үйлдвэрлэл, үйлчилгээний салбараар болон төрийн албаны ангиллаар тус тус дүн шинжилгээ хийж, тоон утгын хамгийн ихээр эрэмбэлэхэд эхний 5 нь дараах байдалтай байна.

Хүснэгт 64. Өргөдөл, гомдол, мэдээллийн бусад

№	Нутаг дэвсгэрийн харьяалал	тоо	хувь	Салбар	тоо	хувь	Төрийн албаны ангилал	тоо	хувь
1	Улаанбаатар хот	521	49.0%	Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах хот	408	38.0%	Төрийн захиргаа	457	42.6%
2	Орхон аймаг	79	7.0%	Уул уурхай	139	13.0%	ТБОНӨХЭ	281	26.2%
3	Сэлэнгэ аймаг	46	4.3%	Зам тээвэр, төмөр зам	69	6.0%	Төрийн улс төрийн	176	16.4%
4	Увс аймаг	44	4.1%	Эрүүл мэнд	63	6.0%	Төрийн үйлчилгээний	92	8.6%
5	Хөвсгөл аймаг г.м	39	3.6%	Барилга г.м	50	5.0%	Бусад г.м	42	3.9%

- ❖ Авлигатай тэмцэх газарт төрийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахад захиалагчийн зүгээс хувийн ашиг сонирхол үүссэн эсэх, хамаарал бүхий этгээдүүд үйл ажиллагаанд оролцсон эсэх зэргээр авлига ашиг, сонирхлын зөрчлийн талаар иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч шалган, шийдвэрлэдэг. Судалгааны дүнгээс харахад судалгааны түүврийн хугацаанд гарсан нийт өргөдөл, гомдол, мэдээллийн 607 нь эрсдэл бүхий гэж тодорхойлогдож шалгагдсанаас 13% нь буюу 80 нь тогтоогдсон байна.
- ❖ Хэдийгээр энэ нь нийт хүлээн авсан өргөдөл, гомдол, мэдээллийн 13% орчим байгаа боловч, үүнээс учирсан хор уршгийг тодорхойлох боломжгүй байна. Иймд цаашид эрсдэл бүхий хэсэгт урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил хийх, хийхээр төлөвлөхөд ач холбогдолтой гэж дүгнэлээ.
- ❖ Сангийн яаманд төрийн худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэгч буюу захиалагчийн нийлүүлэгч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах мэдэгдэл олгосноос хойш ажлын 5 хоногийн дотор гаргасан шийдвэртэй холбоотой, тендер шалгаруулалтын явцад захиалагчид гаргасан гомдлыг ажлын 5 өдрийн дотор шийдвэрлээгүй тохиолдолд тус тус үндэслэл бүхий гомдол гаргадаг.
- ❖ Судалгааны түүврийн хугацаанд Сангийн яаманд 3,320 иргэн, аж ахуй нэгжээс нийт 6,083 гомдол гаргаснаас захиалагчийн гаргасан шийдвэртэй холбоотой 4,664 гомдлыг хянан үзэж үүнээс 3,029 буюу 64.9% нь үндэслэлтэй гэж шийдвэрлэжээ.

Хүснэгт 65. Сангийн яамны шийдвэрлэлт

№	Шийдвэрлэлт	Дүн		Хувь	
1	Гомдол үндэслэлгүй буюу захилагчийн шийдвэр хуульд нийцсэн	854		18.3%	
2	Гомдол үндэслэлтэй үүнээс: үнэлгээ дахин хийх	3,029		64.9%	
			2,808		60.2%

№	Шийдвэрлэлт	Дүн		Хувь	
	<i>ТШ хүчингүй болгосон</i>		221		4.7%
3	Бусад	781		16.7%	
	үүнээс:				
	<i>шүүхэд хандах</i>		323		6.9%
	<i>бүрдүүлбэрийн шаардлага хангаагүй, хуульд заасан хугацаа дууссан гомдол</i>		290		6.2%
	<i>гомдлоо эргүүлэн татсан</i>		127		2.7%
	<i>захиалагчид гомдол гаргах</i>		41		0.9%
Нийт		4,664		100%	

- ❖ Судалгааны дүнгээс харахад судалгааны түүврийн хугацаанд гарсан нийт гомдлын 4,664 нь захиалагчийн гаргасан шийдвэртэй холбоотой эрсдэлтэй гэж шалгагдсанаас 64.9% нь буюу 3,029 гомдол үндэслэлтэй нь тогтоогдсон байна. Өөрөөр хэлбэл захиалагчийн гаргасан шийдвэр хуульд нийцээгүй шийдвэр болохыг тодорхойлсноос зохион байгуулалт хуулийн дагуу хэрэгжээгүй байх тул 221 тендер шалгаруулалтыг хүчингүй болгож, 2,808 тендер шалгаруулалтын үнэлгээг дахин хийхээр шийдвэрлэсэн нь:
 1. цаашид түүнээс учирч болох хор хохирлыг таслан зогсоож,
 2. төрийн худалдан авах ажиллагааны зөрчлөөс урьдчилан сэргийлсэн эерэг нөлөө бүхий захиргааны арга хэмжээ болсон байна.
- ❖ Цаашид шийдвэрлэлтийн талаар үйл ажиллагааны тайланг бичихдээ шийдвэрлэлтийн хуульд нийцээгүй байдлыг илүү тодорхой нийтэд ил тод мэдээлж байх нь зүйтэй бөгөөд энэ нь эрсдэл бүхий хэсэгт урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил хийх, хийхээр төлөвлөхөд чухал ач холбогдолтой гэж дүгнэлээ.

Хүснэгт 66. Монополын эсрэг газрын шийдвэрлэлт

№	Шийдвэрлэлт	Дүн	Хувь
1	Хууль зөрчөөгүй	36	8.7%
2	Гомдол үндэслэлтэй	234	56.7%
	үүнээс:		
	<i>ТБОНӨХБАҮХАТ хууль зөрчсөн</i>	211	51.1%
	<i>Тендерт оролцогч биш</i>	15	3.6%
	<i>Бүхэлд нь хүчингүй болгосон</i>	8	1.9%
3	Бусад	158	38.3%
	үүнээс:		
	<i>гомдол гаргах хугацаа хэтэрсэн</i>	106	25.7%
	<i>Тендерийн нээлт хийсэн</i>	18	4.4%
	<i>гомдлоо дахин гаргасан, буцаан татсан</i>	14	3.4%
	<i>ОУ-ын гэрээгээр зохицуулж байгаа</i>	5	1.2%
Нийт		413	100%

- ❖ Судалгааны дүнгээс харахад судалгааны түүврийн хугацаанд гарсан нийт гомдлын 270 нь өрсөлдөөнийг хязгаарласан байх эрсдэлтэй гэж шалгагдсанаас 86.6% нь буюу 234 гомдол үндэслэлтэй нь тогтоогдсон байна. Өөрөөр хэлбэл тендер шалгаруулалтын баримт бичиг өрсөлдөөн хязгаарласан тухай сонирхогч этгээдийн үндэслэл бүхий гомдлыг гаргасан нь “үндэслэлтэй” буюу 8 тендер шалгаруулалтыг бүхэлд нь хүчингүй болгож, 226 тендер шалгаруулалтын баримт бичиг нь хууль зөрчсөн гэж шийдвэрлэсэн нь:
 1. худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой байдлаар зохион байгуулах,
 2. худалдан авах ажиллагаанд үр ашигтай хэмнэлттэй зарчмыг баримтлан хариуцлага, хяналтын тогтолцоог идэвхжүүлсэн эерэг нөлөө бүхий захиргааны арга хэмжээ болсон байна.
- ❖ Цаашид шийдвэрлэлтийн талаар үйл ажиллагааны тайланг тогтмол бичиж, тэгш өрсөлдөх боломжийг худалдан авах ажиллагаанд баримтлах талаар нийтэд ил тод мэдээлж байх нь зүйтэй бөгөөд энэ нь төрийн худалдан авах ажиллагаанд хуулиар тогтоосон зарчмыг баримтлан хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой гэж дүгнэлээ.

Хүснэгт 67. Судалгааны түүвэрт авагдсан өргөдөл, гомдол, мэдээллийн тоо

№	Байгууллага	Нийт гомдлын тоо	Эрсдэл бүхий тоо		Эрсдэл баталгаажсан тоо		
			тоо	хувь	тоо	нийт гомдолд эзлэх хувь	эрсдэлтэй гомдолд эзэлсэн хувь
		1	2	3 = 2/1	4	5 = 4/1	6 = 4/2
1	АТГ	1,073	607	56.6%	80	7.5%	13.2%
2	СЯ	6,083	4,664	76.7%	3,029	49.8%	64.9%
3	МЭГ	413	270	87.9%	234	56.7%	86.6%
Нийт		7,569	5,691	75.2%	3,375	44.6%	59.3%

- ❖ Судалгаанд сонгосон 2020-2023 онд иргэн, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, худалдан авах ажиллагаанд оролцогч болон сонирхогчдоос Авлигатай тэмцэх газар, Сангийн Яам, Монополын эсрэг газруудад нийт 7,569 өргөдөл, гомдол, мэдээлэл гаргасан байна. Үүнээс нийт гомдлын 75.2% хувь буюу 5,691 өргөдөл, гомдол, мэдээллийг эрсдэл гарсан байх магадлалтай гэж тооцоолон хяналт, шалгалтын ажиллагааг хийснээр тайлант хугацаанд 3,375 өргөдөл, гомдол, мэдээлэл буюу нийт гомдлын 44.6%, эрсдэл гарсан байх магадлалтайд тооцон хяналт, шалгалт хийгдсэн өргөдөл, гомдол мэдээллийн 59.3% эрсдэл нь баталгаажиж шийдвэрлэгдсэн байна.

САНАЛ

Нэг. Хууль эрх зүйн болон зохицуулалтын хүрээнд аль болох хууль эрх зүйн тогтвортой байдлыг хангах:

Хууль эрх зүйн шинэчлэл нь төрийн худалдан авах ажиллагааны эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгосон хэдий ч хуульд ойр ойрхон өөрчлөлт орсноор худалдан авагч, ханган нийлүүлэгчдийн талд найдваргүй байдал үүсгэж, үйл ажиллагаанд хүндрэл учруулж болохыг жилээс жилд өсөж байгаа өргөдөл, гомдол, мэдээллийн тоо, түүнд эзлэх үндэслэлгүй гомдлын шийдвэрлэлт илэрхийлж байна.

- Цаашид хуульд тодорхой бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтыг шууд худалдан авах зохицуулалтыг тодорхой нөхцөлд хэрэгжүүлэхээр өөрчлөлт хийх шаардлагатай байна. Энэ нь зөвхөн үнэ, төсөвт зардлыг бууруулаад зогсохгүй, хамгийн чухал нь хэрэгцээнд илүү сайн нийцсэн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах боломжийг захиалагчид олгодог.
- Монгол Улсын хувьд худалдан авах ажиллагааны тогтолцоо нь төвлөрсөн бус бөгөөд төрийн байгууллагууд худалдан авах ажиллагааны тодорхой төслүүдийг бие даан хэрэгжүүлдэг нь ижил бараа, ажил, үйлчилгээг өөр өөр үнээр, өөр өөр эх үүсвэрээс худалдан авах эрсдэлт нөхцөлийг бий болгож байна. Энэ нь өрсөлдөөнийг нэмэгдүүлсэн, оролцооны тэгш байдлыг хангасан давуу талтай боловч авлига, ашиг сонирхлын зөрчлийг нэмэгдүүлэх сөрөг талыг үүсгэж байна. Иймд төрийн худалдан авах ажиллагаанд төвлөрсөн худалдан авалтыг нэвтрүүлж, хууль эрх зүйн зохицуулалтыг хийх нь төсвийн зарлагын үргүй байдлыг бууруулах, авлигаас урьдчилан сэргийлэх үр дүнтэй.

Хоёр. Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн хамрах хүрээг өргөтгөх, үйл ажиллагааны шинэчлэлт холболтыг тэлэх замаар хууль эрх зүйн болон институци хоорондын тогтолцооны сайжруулалтыг хийх.

Төрийн худалдан авах ажиллагааны газраас цахим систем (www.tender.gov.mn)-ийг “мэдээллийн нэгдсэн цахим модуль, цахим тендер шалгаруулалтын модуль, нийлүүлэгчийн удирдлагын модуль, цахим дэлгүүрийн модуль, цахим шалгалт, цахим сургалтын модуль, худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны мэдээлэл, гар утасны аппликейшн гэсэн үндсэн хэсгээс бүрдсэн худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тендер зарлах, хүлээн авах, тендерийн үр дүнг мэдээлэх, гэрээ байгуулах, гомдол хүлээн авах гэсэн бүх үе шатыг хамарсан нэгдмэл систем⁴¹” гэж тодорхойлжээ.

- Цахим системийг төрийн байгууллагын бусад цахим системтэй холбосон шинэчлэлтийг хийснээр худалдан авах ажиллагаанд гарч буй зөрчил, эрсдэлийн талаарх мэдээллийг төрийн захиргааны байгууллагууд харилцан солилцох нь давхар хяналт тавих боломжийг олгож, авлига, ашиг сонирхлын зөрчлийг бууруулах үр дүнтэй.
- Цаашид тендер сонгон шалгаруулалттай холбоотой гарсан гомдлыг хүлээн авсан төрийн захиргааны байгууллагууд тендер сонгон шалгаруулалтын урилгын кодоор бүртгэж, шийдвэрлэлт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тодорхой өгөгдлөөр хөтөлж байх шинэчлэлтийг хийснээр тухайн зөрчлийг дахин гаргуулахгүй байх, таслан зогсоох, шийдвэрийг хэрэгжүүлсэн эсэхийг хянах хариуцлага, хяналтын тогтолцооны мэдээллийн ил тод байдлыг сайжруулах үр дүнтэй.

⁴¹ Н.Цэрэнсамбуу (2017). “Цахим худалдан авах ажиллагааны өнөөгийн байдал, цаашдын зорилт” илтгэл.

Гурав. Хууль эрх зүйн зохицуулалтын шинэ тогтолцоог хэрэгжүүлэхийн тулд худалдан авах ажиллагаанд оролцогчдын чадавхыг нэмэгдүүлэх.

Төрийн худалдан авах ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, хэрэгжилт, тайлагналын бүх үе шатанд зорилтод үр дүнд хүргэхэд боловсон хүчний мэргэшсэн байдлаас шалтгаалдаг болохыг судлаачид тодорхойлжээ.

✚ Төрийн худалдан авах ажиллагаанд гарч буй эрсдэлийг бууруулахын тулд өндөр ур чадвартай, хангалттай бэлтгэгдсэн боловсон хүчин шаардлагатай. Иймд төрийн худалдан авах ажиллагаанд мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг зөвхөн захиалагчдын ажлын ачааллыг хөнгөвчлөх, тэдэнд хууль эрх зүйн мэдээлэл олгох хүрээнд биш худалдан авах ажиллагааны үе шат бүрд тохирсон агуулга бүхий сонголтод хөтөлбөр бий болгох замаар хэрэгжүүлэх нь үр дүнтэй.

Цаашид төрийн худалдан авах ажиллагааны мэргэшсэн боловсон хүчнийг бэлтгэх, тэдний чадавхыг нэмэгдүүлэх, хэрэгцээнд нийцсэн сургалтын хөтөлбөрийг бий болгоход чиглэсэн тусгайлсан судалгаа явуулж, үр дүнд суурилсан хөтөлбөрийг нэвтрүүлэх нь зүйтэй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

ХУУЛЬ ТОГТООМЖ

1. Авлигын эсрэг хууль
2. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль
3. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль
4. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль
5. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль
6. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
8. UNCITRAL-ийн Бараа (ажил), үйлчилгээ худалдан авах тухай загвар хууль

ХӨТӨЛБӨР, ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ

1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030он)
2. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2023-2030он)
3. Авлигатай тэмцэх газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө
4. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Монополын эсрэг газар (Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар)-т 2022-2023 онд төрийн худалдан авах ажиллагаанд оролцогчдоос гаргасан гомдлын статистик тоо, тайлан
5. НҮБ-ийн тайлан. Cause of corruption in public procurement, According to Ferguson (2018)
6. УИХ-ын Тамгын газар “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн тайлан”, 2021.
7. Сангийн Яам “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2020 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ хийсэн тухай тайлан”
8. Сангийн Яам “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2021 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ хийсэн тухай тайлан”
9. Сангийн Яам “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2022 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ хийсэн тухай тайлан”
10. Сангийн Яам “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ хийсэн тухай тайлан”

ГАДААД ХЭЛ ДЭЭРХ ЭХ СУРВАЛЖ

1. BRAC University, Md. Mahraj Hossain, Degree of Masters “Getting Value for Money from Public Procurement”, January, 2015
2. Buijze, A. (2013). The principle of transparency in EU law. Uitgeverij BOXPress.
3. Corruption in public procurement, March 2017, Vienna
4. Georgieva, I. (2017). Using Transparency Against Corruption in Public Procurement. Cham: Springer
5. Robert Agwot Komakech “Public Procurement in Developing Countries: Objectives, Principles and Required Professional Skills”, Uganda (East Africa) 2016
6. Public Administration, Governance and Globalization, “Global Public Procurement Theories and Practices”, Khi V. Thai Editor, (IPPC7, 2016)

7. Tania Ghossein, Asif Mohammed Islam and Federica Saliola (2018), In “Public Procurement and the Private Business Sector: Evidence from Firm-Level Data”
8. UNODC, Module Series on Anti-Corruption “Module 4. Public Sector Corruption”

ЦАХИМ ЭХ СУРВАЛЖ

1. Авлигатай тэмцэх газрын албан хэрэг хөтлөлтийн “smart office”
2. <https://iaac.mn/>
3. <https://legalinfo.mn/>
4. <https://www.tender.gov.mn/>
5. <https://www.unodc.org/>
6. <https://thedocs.worldbank.org/>
7. <https://data.worldbank.org/>
8. <https://www.mongolbank.mn/>
9. <https://www.fatf-gafi.org/>
10. <https://dx.doi.org/>

Хавсралт №1. Дэлхийн улс орнуудын төрийн худалдан авалтын ДНБ-д эзлэх хувь⁴²

(2018 он)

Дэлхийн улс орнууд, жилийн төсвийн зардлын хэдэн хувийг төрийн худалдан авалтад зарцуулдаг хүснэгтээр харуулав.

№	Улс	ДНБ ² (тэрбум доллар)	ДНБ (хувь) ¹	Төрийн худалдан авах ажиллагааны зардал ³ (тэрбум доллар)
1	Австрали	1,349.0	13.2%	177.4
2	Австри	382.1	13.5%	51.6
3	Бельги	455.0	14.4%	65.7
4	Канад	1,559.6	13.4%	209.6
5	Чех	186.8	14.5%	27.1
6	Дани	301.3	14.2%	42.7
7	Эстони	22.6	14.1%	3.2
8	Финланд	232.5	17.5%	40.8
9	Франц	2,438.2	14.6%	355.5
10	Герман	3,375.6	15.1%	508.0
11	Грек	195.5	11.1%	21.7
12	Унгар	122.9	16.0%	19.7
13	Исланд	16.9	13.8%	2.3
14	Ирланд	290.6	7.3%	21.2
15	Израиль	299.1	14.2%	42.6
16	Итали	1,832.9	10.4%	189.9
17	Япон	4,395.0	16.2%	712.9
18	Солонгос	1,382.8	12.5%	173.4
19	Латви	27.0	12.0%	3.2
20	Люксембург	57.8	12.0%	6.9
21	Мексик	1,169.6	5.2%	60.2
22	Нидерланд	758.0	20.2%	153.0
23	Шинэ Зеланд	177.6	14.7%	26.1
24	Норвеги	386.7	13.9%	53.6
25	Польш	477.4	12.2%	58.1
26	Португал	199.4	9.8%	19.6

⁴² Khi V. Thai, Paul J. Salia and Frederick A. Mwakibinga, (2022) Chapter 1, INTRODUCTION.

Source: 1 OECD (2018). 2 World Bank (2018). 3 Author's calculation, based on OECD and the World Bank data in Columns 2 and 3 of the table.

№	Улс	ДНБ ² (тэрбум доллар)	ДНБ (хувь) ¹	Төрийн худалдан авах ажиллагааны зардал ³ (тэрбум доллар)
27	Бүгд Найрамдах Словак	87.5	17.3%	15.1
28	Словени	43.1	13.4%	5.8
29	Испани	1,197.8	10.5%	125.3
30	Швед	497.9	16.0%	79.7
31	Швейцарь	679.3	8.8%	59.5
32	Турк	859.8	10.9%	93.3
33	Их Британи	2,885.6	13.7%	395.3
34	АНУ	18,120.7	9.4%	1,694.3
	Дүн	46,463.5	13.1%	5,514.1

Хүснэгтээс, Мексик Улс ДНБ-нийхээ 5.15% хувийг, Нидерланд Улс ДНБ-ийхээ 20.18% хувийг гэх зэргээр улс орнууд төрийн худалдан авалтад нэг тэрбум доллараас багагүй зарцуулсан байна. Дэлхийд эдийн засгаараа тэргүүлэгч АНУ ДНБ-нийхээ 9.35% зарцуулсан нь 1,694.3 тэрбум доллар буюу мөнгөн дүнгээр хамгийн их худалдан авалтыг хийсэн байна. Үүнээс, улс орнуудын зарцуулалтын хувиас тооцсон ДНБ-д эзлэх дундаж хувь 13.11% байна.⁴³

⁴³ Khi V. Thai, Paul J. Salia and Frederick A. Mwakibinga, (2022) Chapter 1, INTRODUCTION.

Source: 1 OECD (2018). 2 World Bank (2018). 3 Author's calculation, based on OECD and the World Bank data in Columns 2 and 3 of the table.

Хавсралт №2. Өргөдөл, гомдол, мэдээллийн төрөл (2020-2023 он) дэлгэрэнгүй

№	Шийдвэрлэлт	ГХШ				АСЗХ				Харьяалалд хамаарахгүй				Нийт			
		2020	2021	2022	2023	2020	2021	2022	2023	2020	2021	2022	2023	2020	2021	2022	2023
1	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх	55	82	81	111									55	82	81	111
2	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах	30	49	49	50									30	49	49	50
3	Судалгаанд	26	20	31	59									26	20	31	59
4	Нэгтгэн шалгасан	2	2		2									2	2	0	2
5	Мөрдөн байцаалтын хэрэг нээх			1	1									0	0	1	1
6	Харьяаллын бус	2		1	5									2	0	1	5
7	Харьяаллын дагуу шилжүүлэх	1		1	3									1	0	1	5
8	Зөрчил илрээгүй тул хаасан					42	27	36	58					42	27	37	59

№	Шийдвэрлэлт	ГХШ				АСЗХ				Харьяалалд хамаарахгүй				Нийт			
		2020	2021	2022	2023	2020	2021	2022	2023	2020	2021	2022	2023	2020	2021	2022	2023
9	Бусад төрийн байгууллагад шилжүүлсэн					21	26	13	6					21	26	13	6
10	Зөрчлийг тогтоож шийдвэрлэсэн					8	5	7	7					8	5	7	10
11	Хариу өгч буцаасан					4	6	5	7					4	6	5	7
12	Авлигатай тэмцэх газрын бусад нэгжид шилжүүлсэн							4	29					0	0	4	29
13	Тогтоогдоогүй													0	0	1	0
14	Бусад					1	4	3	6					1	5	4	8
15	(blank)									17	18	17	20	17	18	17	20
16	Нийт	116	153	164	231	76	68	68	113	17	18	17	20	209	240	252	372

Хавсралт №3. Өргөдөл, гомдол, мэдээллийн хуваарилалт хэлтэс, албаар (2020-2023) дэлгэрэнгүй

№	Шийдвэрлэлт	Мөрдөн шалгах хэлтэс				Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс				Гүйцэтгэх ажлын хэлтэс				Нийт			
		2020	2021	2022	2023	2020	2021	2022	2023	2020	2021	2022	2023	2020	2021	2022	2023
1	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээх	55	82	76	104							5	7	55	82	81	111
2	Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах	30	49	49	50									30	49	49	50
3	Мөрдөн байцаалтын хэрэг нээх			1	1									0	0	1	1
4	Судалгаанд									26	20	31	59	26	20	31	59
5	Нэгтгэн шалгасан									2	2		2	2	2	0	2
6	Зөрчил илрээгүй тул хаасан					42	27	36	58					42	27	37	59
7	Бусад төрийн байгууллагад шилжүүлсэн					21	26	13	6					21	26	13	6
8	Зөрчлийг тогтоож шийдвэрлэсэн					8	5	7	7					8	5	7	10

№	Шийдвэрлэлт	Мөрдөн шалгах хэлтэс				Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс				Гүйцэтгэх ажлын хэлтэс				Нийт			
		2020	2021	2022	2023	2020	2021	2022	2023	2020	2021	2022	2023	2020	2021	2022	2023
9	Хариу өгч буцаасан					4	6	5	7					4	6	5	7
10	Тогтоогдоогүй													0	0	1	0
11	Авлигатай тэмцэх газрын бусад нэгжид шилжүүлсэн							4	29					0	0	4	29
12	Харьяаллын дагуу шилжүүлсэн	1		1	3							1	5	1	0	2	12
13	Бусад					1	4	3	6	2				3	5	4	9
14	(blank)	15	18	17	19									17	18	17	19
15	Нийт	101	149	144	177	76	68	68	113	30	22	37	73	209	240	252	374

